



Алсын хараа

Дэлхийн жишиг Монголын банк

Эрхэм зорилго

Хөгжлийн голомт

Стратеги

Нээлттэй банк

Агуулга

01 Удиртгал

02 Компанийн засаглал

03 Эдийн засаг, санхүүгийн тойм

04 Бизнесийн тойм

05 Тогтвортой хөгжил

06 Нийгмийн хариуцлага

07 Үйл ажиллагааны удирдлага

08 Хараат бус аудиторын тайлан

09	Голомт банкны онцлох амжилтууд
11	Санхүүгийн голлох үзүүлэлтүүд
12	Мэндчилгээ

17	Хувьцаа эзэмшигчид
18	Засаглал
22	ТУЗ-ийн бүрэлдэхүүн
26	ТУЗ-ийн дэргэдэх хороод
30	Дотоод аудитын үйл ажиллагаа
32	Удирдлагын баг, бүтэц

39	Эдийн засгийн тойм
47	Банкны салбар
56	Голомт банкны санхүүгийн үр дүн

67	Байгууллагын банк
71	Жижиг, дунд бизнесийн банк
75	Иргэдийн банк
78	Дижитал банк
85	Олон улсын бизнес, хамтын ажиллагаа

93	Тогтвортой хөгжил
----	-------------------

101	Нийгмийн хариуцлага
-----	---------------------

107	Хүний нөөцийн удирдлага
111	Хөрөнгийн удирдлага
112	Эрсдэлийн удирдлага
120	Комплаенс

122	Хараат бус аудиторын тайлан
-----	-----------------------------

Удиртгал



Удиртгал

Нийт актив

11.6

их наяд төгрөг

Банкны нийт актив өмнөх оноос 2.6 их наяд төгрөгөөр буюу 29.4 хувиар өсөж, 11.6 их наяд төгрөгт хүрснээр зах зээлд эзлэх хувь 20.1% болж өслөө.

Голомт банкны онцлох амжилтууд

EUROMONEY

Монгол Улсын Шилдэг
банк 2023

ASIAMONEY

Монгол Улсын Шилдэг
банк 2023

GLOBAL
FINANCE

Монгол Улсын Шилдэг
Дижитал банк 2023

Great
Place
To
Work®

Ажиллахад хамгийн
таатай газар 2023

Голомт банк Монгол Улсын банкны салбарт технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмын шинэчлэл хөгжүүлэлтийг тогтмол хийж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлийг бий болгон, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн сайжруулалт, хөгжүүлэлтүүдийг хийж ажиллалаа.

Дижитал сувгийн нийт хэрэглэгчийн тоо

+16.4%

Кредит картын зах зээлд эзлэх хувь

48%

Дижитал сувгаар хийгдсэн нийт гүйлгээний тоо

+38.6%

Банкны салбарт нийт зээлийн хэмжээгээр эзлэх хувь

17.5%

SocialPay үйлчилгээгээр хийгдсэн нийт гүйлгээний тоо

+121.4%

Харилцагчийн эх үүсвэрийн хэмжээгээр зах зээлд эзлэх хувь

20.0%

Нийт актив
11.6 их наяд төгрөг

+29%

Татварын дараах цэвэр ашиг
209.2 тэрбум төгрөг

+80%

Жижиг, дунд бизнесийн зээлийн багц

+28%

Нийт хэрэглээний зээлийн багц

+35%


Байгууллагын нийт эх үүсвэр

+68%

Санхүүгийн голлох үзүүлэлтүүд


Нийт хөрөнгө

11,628 тэрбум ₮




Өөрийн хөрөнгө

1,071 тэрбум ₮




Харилцах, хадгаламж

8,037 тэрбум ₮




Цэвэр зээл

4,712 тэрбум ₮



Цэвэр ашиг

209 тэрбум ₮



Мэндчилгээ



Ч.Мөнхцэцэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Эрхэм хүндэт харилцагчид, хувьцаа эзэмшигчид, түншүүд, хамтран ажиллагчид аа,

Голомт банк олон нийтэд нээлттэй хувьцаат компани болж, хөгжил дэвшлийнхээ дараагийн шатанд гарснаас хойш хоёр дахь жилээ үдэж, банк, санхүүгийн салбартаа тэргүүлэгч байр сууриа хадгалан дэвшилтэт технологи суурьтай бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хөгжүүлж, ололт амжилтаа бэхжүүлэн ажиллалаа.

2023 онд Монгол Улсын эдийн засгийг хөдөлгөгч уул уурхай, барилга, боловсрол, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнс, хөдөө аж ахуй зэрэг бүхий л чухал салбарт санхүүжилт олгон эх орны хөгжилд хувь нэмрээ оруулан ажилласан жил байв.

Тайлант хугацаанд Голомт банкны нийт актив 2.6 их наяд төгрөгөөр өсөн 11.6 их наяд төгрөгт хүрч, 209.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд банкны өөрийн хөрөнгө 1,071 тэрбум төгрөгт хүрсэн байна. Түүнчлэн зээлийн хэмжээ 4.9 их наяд төгрөгт хүрч, банкны салбарт нийт зээлийн хэмжээгээр 17.5%-ийг бүрдүүлсэн бол активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн харьцааг 5.0 хувьд хүргэн бууруулж, банкны системийн чанаргүй зээлийн хувиас доогуур буюу сайн үзүүлэлттэй гарсан байна.

Бид тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, энэ чиглэлийн бизнесийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүд, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Сүүлийн жилүүдэд гадаад, дотоодын нийт 40 гаруй төслийн зээлийн хөтөлбөрүүдэд идэвхтэй оролцож, байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг үр ашгийг нэмэгдүүлэн ажиллалаа. Тодруулбал, 2023 оны байдлаар банкны салбарын нийт ногоон зээлийн багцын 22.9 хувийг Голомт банк бүрдүүлжээ. Харин хамтын ажиллагааны хүрээнд Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Азийн Хөгжлийн банктай худалдааны санхүүжилтийн шугамыг дахин сэргээж, олон улсын томоохон хөрөнгө оруулалтын сангуудаас нийт 127.7 сая ам.долларын санхүүжилт татсан бөгөөд цаашид ч санхүүжилтийн хэмжээг өсгөн нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Жижиг, дунд бизнес, тэр дундаа бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих, эмэгтэй удирдлагатай бизнесийг олон нийтэд таниулан сурталчлах зорилгоор Голомт банк МҮХАҮТ-тай хамтран "Women owned" тохирлын тэмдгийг анх удаа нэвтрүүллээ. Ингэснээр бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг тодорхойлох, аливаа бодлого, стратегийг хэрэгжүүлэх, хамтрал үүсгэх замаар бизнесийн борлуулалтыг нь нэмэгдүүлэх төсөл, хөтөлбөрүүдийн уялдаа холбоог сайжрууллаа.

Голомт банкны үйл ажиллагаа, ололт амжилтыг үнэлэн дэлхийн банк, санхүүгийн салбарт нэр хүндтэй "Euromoney" болон "Asiamoney" сэтгүүлээс Голомт банкныг 2023 оны "Монгол Улсын Шилдэг банк"-аар тодруулсан бол "Global Finance" сэтгүүлээс "Монгол Улсын Шилдэг Дижитал банк"-аар шалгаруулсан юм. Мөн "Great place to work institute"-ээс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн "Ажиллахад хамгийн таатай газар" батламжийг Монгол Улсын банк, санхүүгийн салбараас хоёр дахь жилдээ дараалан авснаар дэлхийд тэргүүлэгч, томоохон байгууллагуудтай ижил түвшинд үнэлэгдэн байгууллагын соёлоороо тэргүүлж байгаа гэдгийг дахин баталгаажууллаа.



Норихико Като

Гүйцэтгэх захирал

Бид тогтвортой
хөгжлийн
бодлогын хүрээнд
ногоон зээлийн
хүртээмжийг
нэмэгдүүлэх,
энэ чиглэлийн
бизнесийн үйл
ажиллагааг
дэмжихэд чиглэсэн
төсөл, хөтөлбөрүүд,
үйл ажиллагааг
хэрэгжүүлдэг.

Голомт банкны 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, ололт амжилтууд нь банкны нийт харилцагч, хувьцаа эзэмшигчид, түншүүд, хамтран ажиллагч байгууллагууд болон эх орныхоо хөгжлийн голомт байх эрхэм үүргээ нэр төртэй, хариуцлагатай гүйцэтгэж яваа ажилтнуудын маань хичээл зүтгэлийн үр шим бөгөөд бидний үйл ажиллагааг дэмжин итгэл хүлээлгэсэн эрхэм та бүхэнд талархал илэрхийлье!

Бидний хувьд 2024 онд Дэлхийн жишиг Монголын банк байх алсын хараагаа эрхэмлэн банк, санхүүгийн салбартаа тэргүүлэгч байж, эрхэм харилцагч, түнш, хувьцаа эзэмшигчид хамтрагчдынхаа хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхолд бүрэн нийцсэн банк, санхүүгийн шилдэг, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэн сайжруулж, хамгийн сайн засаглалын тогтолцоо, нээлттэй, ил тод байдлаа бэхжүүлэн ажиллахаа илэрхийлж байна.

Хүндэтгэсэн,



Ч.Мөнхцэцэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга




Норихико Като

Гүйцэтгэх захирал

Компанийн засаглал





Компанийн засаглал

Олон нийт

11.6%

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний дийлэнх хувийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс ангид жижиг хувьцаа эзэмшигчид болон хараат бус гишүүд эзэлж байна. Энэ нь Голомт банкны ТУЗ-ийн тогтолцоо нэг талын нөлөөнд автсан шийдвэр гаргах эрсдэлгүй гэдгийг батлан харуулж байна.

Хувьцаа эзэмшигчид

Голомт банкны нийт хувьцааны 11.6 хувь буюу 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.

Голомт Файнэншил Групп ХХК

77.20%

Голомт Файнэншил Групп ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн чиглэлээр бизнесийн төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг 100 хувь Монголын хөрөнгө оруулалттай компани юм. Тус компани нь урт хугацааны хөрөнгө оруулалтын бодлого баримталдаг ба Голомт банкны энгийн хувьцааны дийлэнх хувийг эзэмшдэг.

Свисс-Мо Инвестмэнт Эй Жи

5.21%

Свисс-Мо Инвестмэнт Эй Жи нь Швейцарь улсын хөрөнгө оруулалтын сан бөгөөд 2010 онд үүсгэн байгуулагдсан. Валют арилжаа, нисэх онгоцны буудал, агаарын тээвэр болон зочид буудлын салбаруудад үйл ажиллагаа эрхэлдэг. 2011 онд Голомт банканд хөрөнгө оруулалт хийснээр хувьцаа эзэмших болсон.

Бодь Интернэшнл ХХК

3.42%

Бодь Интернэшнл ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттайгаар 1993 онд байгуулагдсан, томоохон групп компаниудын нэг бөгөөд өдгөө үл хөдлөх хөрөнгийн хөгжүүлэлт, удирдлага, барилга, эрчим хүч, уул уурхай, амралт аялал жуулчлалын салбаруудад үйл ажиллагаагаа явуулдаг.

Голомт Инвестмэнт Лимитэд

2.57%

Голомт Инвестмэнт Лимитэд нь 2014 онд Монголын анхны томоохон групп компани болох "Бодь интернэшнл" ХХК-ийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан.

Олон нийт

11.60%

Голомт банк 2022 оны 11-р сард нийт хувьцааныхаа 10.09 хувийг санал болгож, анхдагч зах зээлийн арилжааны нээлтийг хийсэн. 2023 оны байдлаар банкны нийт хувьцааны 11.6 хувь болох 93 мянга гаруй нэгж хувьцааг олон нийт эзэмшиж байна.

Засаглал

Голомт банк ТУЗ-ийн тогтоолоор батлагдсан “Голомт банкны засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна. Засаглалын кодексыг Голомт банкны бүх ажилтан, албан тушаалтнууд сахин мөрдөх үүрэгтэй бөгөөд хэрэгжилтийг Голомт банкны ТУЗ хянадаг. Тайлант хугацаанд Голомт банкны засаглалын гол оролцогч талууд болох Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага ба түүний багийн гишүүд цаг үеийн шинжтэй аливаа нөхцөл байдлыг банкны засаглалын тогтолцоо системчлэгдэн бүрдсэний үндсэн дээр тухай бүр шуурхай шийдвэрлэн өөрчлөлтөд дасан зохицож, сорилтыг даван туулж онцлох амжилтаар дүүрэн жил байв.

Голомт банкны засаглалын тайлан

Голомт банкны ТУЗ нь засаглалын практикийг олон улсын жишиг болон ёс зүйн хэм хэмжээний хүрээнд хууль тогтоомжийн дагуу, тогтвортой, тууштай баримтлахыг үүрэг болгон ил тод, хариуцлагатай байдлыг эрхэмлэж, салбарын стандартад үлгэр жишээ соёлыг төлөвшүүлэхийг зорьдог. Тайлант хугацаанд банкны стратегийн шийдвэрүүдийг эрсдэлийн удирдлагын зохистой зарчимд тулгуурлан банкны тогтвортой байдал, бизнесийн үйл ажиллагааны тэлэлт, хувьцаат компани болсонтой холбоотой ил тод байдлыг чухалчилж ажиллалаа. Жижиг хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын итгэлцэлд ТУЗ-ийн амлалт нэн чухал тул засаглалын тогтолцооныхоо үр нөлөөг нэмэгдүүлэхийн төлөө хичээн ажилладаг.

Манлайлал

Банкны засаглалын тогтолцоог бэхжүүлэх, ёс зүйн хэм хэмжээг баримтлан ажилладаг соёлыг төлөвшүүлэх чиг хандлагыг тодорхойлоход ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын багтай нягт хамтран ажилладаг бөгөөд шударга ёс, шинийг санаачлагч, стратегийн алсын харааг зарчим болгосон шийдвэрийг ямагт хэрэгжүүлж байдаг. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын баг нь цаг үетэй уялдуулан холбогдох дүрэм журмыг шинэчлэн үйл ажиллагаагаа явуулдаг билээ.

Голомт банкны ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь байгууллагын эрхэм зорилго, үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлж, амжилт, тогтвортой байдалд чухал үүрэг гүйцэтгэдэг мэргэжлийн туршлагатай оролцогч талуудыг төлөөлсөн хараат бус гишүүдээс бүрдсэн байна.

Стратеги ба гүйцэтгэл

Тайлант хугацаанд Голомт банк дунд хугацааны стратеги төлөвлөгөөг нарийвчлан тодорхойлж, албан ёсоор ТУЗ баталж ажиллалаа. Стратеги шинэчлэлийн хүрээнд Голомт банкны томоохон бодлогуудыг шинэчлэн сайжруулсан. Тухайлбал:

- Мэдээллийн технологийн бодлого
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого
- Дата удирдлагын бодлого
- Актив пассивын удирдлагын бодлого
- Хүний нөөцийн удирдлагын бодлого
- Маркетингийн бодлого
- Харилцагч төвтэй банкны бодлого
- Бизнесийн процессын удирдлагын бодлого
- Эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн аппетит
- Зээлийн бодлого, зээлийн эрхийн матриц

Стратеги төлөвлөлт хийх процессыг сайжруулаад зогсохгүй бид төсөв төлөвлөгөөний гүйцэтгэлийн хяналт, гүйцэтгэлд суурилсан урамшууллын системийг тогтмол сайжруулахад анхаарч ажилладаг. Төсөв төлөвлөгөөний гүйцэтгэл, санхүүгийн тайлан мэдээллүүдийг тогтмол ТУЗ-д тайлагнахаас гадна Дотоод аудитын газраар тогтмол давхар баталгаажуулалт хийгдэж байна. Мөн Гүйцэтгэх удирдлагын ажлын гүйцэтгэлийг үнэлж, гэрээний үзүүлэлтүүдийг хувь хүн болон баг хамт олон, банкны нийт гүйцэтгэлтэй уялдуулж, бие даан шийдвэр гаргах, нэг зорилгын дор багийн нийцэл ажиллагааг тэнцвэртэй үнэлэн дүгнэдэг.

Хөрөнгө оруулагч

Голомт банк хувьцаат компани болсонтой холбогдуулан Хөрөнгө оруулагчидтай харилцах албыг байгуулан хувьцаа эзэмшигчдэд цаг алдалгүй мэдээлэл хүргэх, цахим хуудас хөгжүүлэхийн зэрэгцээ олон нийтэд мэдээлэл хүргэх, цахим шуудангаар санал хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хувьцаа эзэмшигчдийг биечлэн хүлээн авч уулзах, албан бичгээр мэдээлэл, мэдэгдлийг эрх бүхий байгууллагууд, хувьцаа эзэмшигчид, харилцагч нарт тухай бүрд хүргүүлэн, хүлээн авах зэрэг компанийн үйл ажиллагааг ил тод, түргэн шуурхай явуулах механизмуудыг хэрэгжүүлэн ажиллав.

Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагуудын дүрэм журмын дагуу компанийн засаглал, үйл ажиллагаа болон холбогдох санхүүгийн мэдээллийг зохицуулагч байгууллага болон олон нийтэд цаг тухайд мэдээлэн хамтарч ажиллалаа.


Ёс зүй

Байгууллагын соёл, дотоод эерэг уур амьсгалыг бэхжүүлэх болон нийт ажилтны дагаж мөрдөн үйл ажиллагаандаа баримтлах чухал засаглал болон соёлын бодлогын баримт бичиг болох “Code of Conduct”-ийг ТУЗ-өөс санаачлан баталсан. Шинэ санаачилгыг дэмжих, олон улсын туршлагыг судлах хүрээнд ТУЗ нь банкны “Code of Conduct”-ийг 18 зүйлтэй, хэрэгжүүлэх төлөвлөгөөний хамт 2023 оны 12 дугаар сарын 28-ны тогтоолын хавсралтаар баталсан нь ёс зүйн хэм хэмжээг дэмжих томоохон амжилт болсныг онцлох нь зүйтэй.

Голомт банкны засаглалын тогтолцоо

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн бүрэлдэхүүний дийлэнх хувийг нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдээс ангид жижиг хувьцаа эзэмшигчид болон хараат бус гишүүд эзэлж байна. Энэ нь Голомт банкны ТУЗ-ийн тогтолцоо нэг талын нөлөөнд автсан шийдвэр гаргах эрсдэлгүй, хамгийн эрүүл гэдгийг батлан харуулж байна. ТУЗ-ийн удирдан чиглүүлэх үндсэн ажлыг гүйцэтгэхэд өндөр хувь нэмэр оруулахуйц банк санхүүгийн мэргэшсэн мэргэжилтнүүдээр зөвлөлөө бүрэлдүүлсэн ба Дотоод аудитын газар, Аудит хариуцсан захирал нарыг ТУЗ-өөс томилон удирдаж, хяналтын тогтолцоогоо зохистой байдлаар бүрдүүлэн ажиллаж байна.

2023 онд Голомт банкны ТУЗ нийт 14 удаа ээлжит болон ээлжит бус байдлаар хуралдаж, 40 асуудлыг шийдвэрлэн Тогтоол гаргасан байна.



● Сонгох/томилох

● Тайлагнах/мэдээлэх

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



Ч.Мөнхцэцэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Ч.Мөнхцэцэг нь 1988 онд Зөвлөлтийн 3-р бүрэн дунд сургууль, 1993 онд Политехникийн их сургуулийг Уул уурхайн цахилгаан механикийн инженер, 2001 онд АНУ-ын Жонс Хопкинсийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн. 2015 онд Англи улсын Оксфордын их сургууль, 2016 онд АНУ-ын Харвардын их сургуульд тус тус мэргэжил дээшлүүлсэн.

Ажлын гараагаа 1996 онд Монголын Хөрөнгийн Биржээс эхлүүлж, Дэлхийн банк, Азийн сан зэрэг байгууллагуудад ажиллаж байсан.

2010 оноос “Тойм” сэтгүүлийг эрхлэн гаргаж байсан бөгөөд 2012 оны 12-р сард Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдож, 2013 оны 12-р сараас Голомт банкны ТУЗ-ийн даргаар сонгогдон ажиллаж байна.



Урс Э.Шварценбах

ТУЗ-ийн гишүүн

Урс Э.Шварценбах нь Швейцар улсын Цюрих хотын Худалдааны коллежийг дүүргэж, 1968 онд Цюрих, 1972 онд Лондон дахь Юнион банканд ажилласан. 1976 оноос өөрийн бизнесийг эхэлсэн бөгөөд 2000 онд Канад улсын Нова Скотиагийн "St. Francis Xavier" Их сургуулийн Хүндэт доктор цолоор шагнуулсан.

Урс.Э.Шварценбах нь 2010 оны 1-р сард Швейцар улсад оршин суугаа ХБНГУ-ын иргэдийг төлөөлөн Монгол Улсын хүндэт консулаар өргөмжлөгдсөн.

2011 оноос эхлэн Голомт банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Ж.Үнэнбат

ТУЗ-ийн гишүүн

Ж.Үнэнбат нь 1985 онд Москвагийн Эдийн засаг, статистикийн дээд сургуулийг Эдийн засагч, статистикч мэргэжлээр төгсөж, 1994 онд АНУ-ын Нью-Йоркийн Колумбын их сургуульд Олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэг хамгаалсан, дэд профессор цолтой.

1990 оноос Монголбанканд ажиллаж эхэлсэн бөгөөд 1996 оноос 2000 онд Монголбанкны Ерөнхийлөгч, 2000-2006 онд Монголын банкны холбооны Гүйцэтгэх захирал, 2009 оноос Компанийн засаглалын хөгжлийн төвийн Гүйцэтгэх захирал, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн Санхүүгийн тэнхимийн эрхлэгчээр ажилласан. Мөнгөний бодлогын чиглэлээр судалгааны олон ажил хийж, банк санхүүгийн чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан нэгэн юм.

2010 онд Голомт банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдож, 2020 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



Д.Мөнхтөр

ТУЗ-ийн гишүүн

Д.Мөнхтөр нь 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Санхүүгийн удирдлагын бакалавр зэрэгтэй, 2009 онд АНУ-ын Оклахомагийн Их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр дүүргэсэн.

1996 оноос Голомт банканд Туслах ажилтнаас эхлэн Эдийн засагч, Зээлийн газрын захирал, Бүртгэл тооцооны газрын захирал, 2011 оноос Тэргүүн дэд захирлаар ажилласан туршлагатай. Одоо Цэцэнс Майнинг Энд Энержи ХХК-д Гүйцэтгэх удирдлагын үүрэгт ажлыг гүйцэтгэж байна.

Тэрээр "Ажилтанд хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд хувьцаа эзэмшигч болсон бөгөөд эдгээр 149 цөөнх хувьцаа эзэмшигчийг төлөөлж, 2012 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн



О.Ганжолоо

ТУЗ-ийн гишүүн

О.Ганжолоо нь ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт их сургуульд Эдийн засгийн онолын чиглэлээр магистр, докторын зэрэг хамгаалсан. ИБУИНХУ болон Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогч юм. Тэрээр "PwC International Limited" компанийн Герман болон Монгол дахь салбаруудад ажиллаж байсан бөгөөд өмнө нь "Бодь Интернэшнл" ХХК-ийн Санхүү хариуцсан захирал, 2016-2023 он хүртэл "Голомт Файнэншил Групп" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. 2022 онд ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон.



Жэймс Б.Двайер

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Жеймс Б.Двайер нь Нотр Дамын их сургуульд Бизнесийн удирдлагын бакалавр, АНУ-ын Колумбийн их сургуульд Бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр 1970 оноос хойш Швейцарийн Юнион банкны хил дамнасан нэгдэл, худалдан авалт хариуцсан даргаар ажиллаж, "Wallstreet"-д төвтэй хөрөнгө оруулалтын банкуудад ажиллаж байсан хөрөнгө оруулалтын банкны арвин туршлагатай.

Ноён Жеймс Б.Двайер нь 2001 онд Хаан банк, Худалдаа хөгжлийн банкны хувьчлалын хөрөнгө оруулалтын банкираар ажиллаж байсан бөгөөд Хойд Америкийн бизнесийн зөвлөлийн Үйл ажиллагаа хариуцсан захирлаар, 2007 онд "Монголын Бизнесийн зөвлөл"-ийг байгуулж, 2017 он хүртэл Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Мандал Даатгал ХК, Монголиа Гроут Групп ХХК, Монголын Финтек Групп ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Монголын мэдээллийн сангийн түнш, ТУЗ-ийн гишүүнээр ажилладаг. Ноён Б.Двайер 2018 оноос Банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж эхэлсэн.



Александр Пикер

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Александр Пикер нь Австри улсын Зальцбургийн их сургуульд Бизнес, хуулийн чиглэлээр магистр, докторын зэрэг хамгаалсан. Тэрээр 1989 онд одоогийн Австрийн банкнаас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд Die ERSTE банк, Олон улсын Москва банк (IMB), ATFBank, Нуро Alpe-Adria Bank, HBI Bundesholding AG зэрэг байгууллагуудад Эрсдэл хариуцсан захирал, Үйл ажиллагаа хариуцсан захирал болон Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан туршлагатай.

Ноён Александр Пикер нь Дэлхийн банкны томоохон төслүүдийн ахлах зөвлөх, Узбекистаны Ипотека банкны Хяналтын зөвлөлийн даргаар ажиллаж байсан. Тэрээр 2023 онд Молдав улсын Молдиндконбанкны Гүйцэтгэх захирлаар ажиллаж эхэлсэн. 2021 оноос хойш Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байна.


Роберт В.Ван Свитен
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ноён Роберт В.Ван Свитен нь Нидерландын Хаант Улсын Лейден их сургууль болон АНУ-ын Колумбын их сургуулийг Хууль зүйн бакалавр, “Chicago Booth” их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн.

Роберт В.Ван Свитен нь дэлхийн санхүүгийн зах зээл болон тогтвортой хөгжлийн салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр “Serendra Group”-ийн Гүйцэтгэх захирал, “SeaOil Philippines Inc.”-ийн ТУЗ-ийн гишүүн, Засаглалын хорооны дарга, “Hong Bao Media Holdings Pte Ltd”-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүүгийн хорооны даргаар ажиллаж байна. Өмнө нь хөгжиж буй зах зээл дэх хувийн хөрөнгийн дэлхийн аж үйлдвэрийн холбоо болох ЕМРЕА (одоо GPCA нэртэй)-ны Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, Сингапурын бирж, “Lehman Brothers”, “General Electric”, “ABN AMRO” банк зэрэг фирмүүдэд удирдах албан тушаал хашиж байсан бөгөөд Азийн хөгжлийн банкны Хувийн салбарын хөрөнгийн зах зээлийн Хэлтсийн захирлаар ажиллаж байсан. 2023 оноос Голомт банкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.


З.Солонго
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

З.Солонго нь 2003 онд Энэтхэг улсын Гужарат мужийн Сардар Пател их сургуулийн бакалавр, 2017 онд СЭЗИС-ийн Компанийн засаглалаар мэргэшсэн Бизнес удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.

2017 онд Олон улсын санхүүгийн корпораци (IFC)-аас Сингапур улсад зохион байгуулсан Ази бүсийн ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын мастер хөтөлбөрт хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн. 2007 оноос хойш Голомт банканд ажиллахдаа Гүйцэтгэх захирлын түвшинд Нарийн бичгийн дарга, Туслахын албан тушаал хашиж, 2015 оны 9-р сараас хойш Голомт банкны ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.


А.Туяа
Дотоод аудитын газрын захирал

А.Туяа нь 2008 онд ХУИС-ийн Санхүүгийн удирдлагын бакалавр, МУБИС-ийн Боловсролын бакалавр, 2015 онд Австралийн үндэсний их сургуулийн Санхүүгийн магистрын зэрэг хамгаалсан.

Тэрээр 2008-2017 онд Голомт банкны Дотоод аудитын газарт аудитор, 2017-2019 онд Дотоод аудитын газрын Мэдээллийн технологи, Гүйцэтгэлийн аудитын хэлтэст ахлах аудитор, 2019 оноос 2023 онд Дотоод аудитын газрын Зайны аудит, Чанарын баталгаажуулалтын хэлтсийн захирлаар тус тус ажилласан бөгөөд 2023 оноос Голомт банкны Дотоод аудитын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Эрсдэлийн удирдлагын хороо

ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн нь 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн тогтоолоор өөрчлөн батлагдсантай холбоотойгоор Эрсдэлийн удирдлагын хороо нь дараах бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

Дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Александр Пикер

Гишүүд:

ТУЗ-ийн дарга	Ч.Мөнхцэцэг
ТУЗ-ийн гишүүн	Ж.Үнэнбат
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Жэймс Б.Двайер
ТУЗ-ийн хараат бус гишүүн	Роберт В.Ван Свитен

Голомт банкны Эрсдэлийн удирдлагын хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн даргалдаг. ТУЗ-ийн хараат бус 3 гишүүн болон энгийн 2 гишүүнээс бүрддэг ба сард дунджаар 1 удаа хуралдаж, банкны нийт эрсдэлийг зохистой байдлаар тодорхойлж, эрсдэлийн хүлээн зөвшөөрч болох хэм хэмжээг тогтоон, хэрэгжилтийг хангаж ажилладаг болно.

Тус хороо нь банкны нийт эрсдэл буюу санхүүгийн ба санхүүгийн бус эрсдэл, зээл, үйл ажиллагааны болон комплаенсийн эрсдэлийг удирдах асуудлыг банкны бодлогын хэмжээнд хангаж ажиллах, хэрэгжилтийг хянах гол чиг үүрэгтэй. Тиймээс тус хорооны дүрэмд тусгагдаж, бүтцээр хангагдсанаар Эрсдэл хариуцсан захирал, Комплаенс хариуцсан захирал нь тус хороонд тайлагнах журамтай бөгөөд Эрсдэл хариуцсан захирлын гол анхаарч ажиллах асуудал болон жилийн төлөвлөгөөтэй танилцаж, үүрэг зөвлөмжөөр ханган ажилладаг.

Банкны үйл ажиллагааны хувь зээлийн эрсдэл нь гол удирдах шаардлагатай эрсдэлүүдийн 1-рт ордогтой холбоотойгоор тус хороо нь 20 тэрбум төгрөг буюу түүнээс дээш зээл болон түүнтэй адилтгах активын үүрэг хүлээсэн групп компаниудын Зээлийн хорооны шийдвэрийг хянах функцтэй ажилладаг. Гүйцэтгэх захирлын удирддаг Зээлийн хорооны шийдвэрийг хянаж үзээд эрсдэлтэй гэж үзвэл тус шийдвэрийг хэрэгжүүлэхэд "Хориг тавих" эрхтэй. Тиймээс ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо нь банкны бүхий л томоохон эрсдэлүүдэд анхаарч, удирдан чиглэл өгч ажилладаг болно. Тус хороо нь тайлант хугацаанд нийт 25 удаа хуралдаж, 91 асуудал хэлэлцсэн байна.


Эрсдэлийн удирдлагын хорооны зөвлөмжийн дагуу ТУЗ нь дараах гол бичиг баримтуудыг батлан Гүйцэтгэх удирдлагад хэрэгжүүлэх чиг үүрэг өгч хянадаг болно. Үүнд:

1. Risk Appetite Framework / Risk Appetite Statement
Эрсдэлийн аппетитийн бодлого бичиг баримт
2. Эрсдэлийн лимитүүд
3. Зээлийн бодлого
4. Зээлийн хорооны дүрэм
5. Комплаенсийн бодлого
6. Засаглалын кодекс дахь бодлогын бичиг баримтууд:
 - Ёс зүйн дүрэм
 - Авлигын эсрэг бодлого
 - Сонирхлын зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх журам
 - Мэдээллийн тэнцвэртэй байдлын бодлого
 - Луйврын эсрэг бодлого
 - Улс төрийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бодлого
 - Зөрчлийн мэдээлэх тухай бодлого – шүгэл үлээх

Эрсдэлийн удирдлагын хорооны тогтмол авдаг тайлангууд:

1. Эрсдэлийн тайлан:
 - Санхүүгийн эрсдэл:
 - Зах зээлийн эрсдэл
 - Зээлийн эрсдэл
 - Зээлийн багцын мэдээлэл – сар бүрээр
 - Санхүүгийн бус эрсдэл:
 - Үйл ажиллагааны эрсдэлийн тайлан
 - Комплаенсийн эрсдэлийн тайлан
 - МУТСТэмцэх үйл ажиллагааны тайлан
2. Гүйцэтгэх удирдлагын түвшний Эрсдэлийн удирдлагын хорооны тайлан
3. Зээлийн хорооны тайлан
4. Зээлийн хорооны шийдвэр
5. Эрсдэлийн бодлогын хэрэгжилт – RAF/RAS эрсдэлийн метрикүүдийн хэрэгжилт

Хэлэлцсэн асуудлууд



16%

Банкны бизнес төлөвлөгөөний гүйцэтгэл, санхүүгийн үр дүн

33%

Дотоод аудитын тайланг тайлагнах

24%

Дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэлийг тайлагнах, төлөвлөгөөг батлуулах

3%

Монголбанкны шалгалтын үр дүн

8%

Хөндлөнгийн аудитын үр дүн

16%

Бусад

Аудитын хороо

Голомт банкны ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь 2023 онд 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулсан бөгөөд Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Жеймс Б.Двайер ажиллаж байна.

Аудитын хороо нь дараах үйл ажиллагаатай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг.

- Санхүүгийн тайлантай холбоотой
- Дотоод хяналтын тогтолцоотой холбоотой
- Дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Хөндлөнгийн аудитын үйл ажиллагаатай холбоотой
- Комплаенсын үйл ажиллагаатай холбоотой
- Тайлагналын үйл ажиллагаатай холбоотой
- Бусад үйл ажиллагаатай холбоотой

Аудитын хороо нь 2023 онд ээлжит болон ээлжит бусаар нийт 10 удаа, дунджаар 92%-ийн ирцтэй хуралдаж, 37 асуудал хэлэлцэн шийдвэрлэсэн.

Аудитын хороо нь шаардлагатай тохиолдолд хорооны эрхлэх асуудлын хүрээнд тусгайлсан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулах, банкны нууцад хамаарах баримт, материалтай танилцах, холбогдох албан тушаалтнаар мэдээлэл гаргуулах эрхтэй байна. Дотоод аудитын болон хөндлөнгийн аудитын тайлан, илэрсэн зөрчил, зөвлөмжүүд нь Аудитын хороонд шууд тайлагнагддаг.

Аудитын хороо нь банкны сар бүрийн санхүүгийн үзүүлэлтүүдийг хянаж, Удирдлагын багт үүрэг, зөвлөмж өгдөг. Мөн хөндлөнгийн аудитын тайлан, Монголбанкны шалгалтын үр дүнг хэлэлцэж, батлах саналыг ТУЗ-д хүргүүлж ажилладаг.

Аудитын хороо нь нягтлан бодох бүртгэлийн стандарт, хууль эрх зүйн орчинд гарч буй санхүүгийн тайлагналд нөлөө үзүүлэхүйц өөрчлөлтүүд, банкны нэр хүндийн эрсдэлд оруулж болзошгүй асуудлын талаар байнгын мэдээлэлтэй байдаг.

Аудитын хороо нь Дотоод аудитын үйл ажиллагааны эрх, үүргийг тусгасан дүрэм, үйл ажиллагааны журам, эрсдэлд суурилсан дотоод аудитын төлөвлөгөөг хэлэлцэж, холбогдох саналыг ТУЗ-д хүргүүлдэг. Мөн Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг, үйл ажиллагаандаа олон улсын стандарт, арга аргачлал, сайн туршлагыг нэвтрүүлж буй эсэхийг болон аудитын тайлан, тайлангаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянадаг. Аудитын хороо нь Аудит хариуцсан захирлыг томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-д хүргүүлж, дотоод аудитын үйл ажиллагааны нэгжүүдийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, цалин урамшууллыг тогтоодог.

Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаанаас Нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой хэсгийг салган шинээр байгуулсантай холбоотойгоор тус хороог 3 гишүүнтэйгээр өөрчлөн байгуулж, ТУЗ-ийн 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн тогтоолын хавсралтаар хорооны дүрмийг шинэчлэн батлав.

Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн дараах байдлаар ажиллаж байна. Үүнд:

Дарга:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Жэймс Б. Двайер

Гишүүд:

ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг

ТУЗ-ийн хараат бус гишүүн Александр Пикер

Тус хороо нь Голомт банкны Засаглалын кодекс болон түүнд багтсан бүх бодлогуудын хэрэгжилтийн асуудлыг хамаардаг ба Гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх, цалин хөлс, урамшууллын системийг боловсруулах, батлахад ТУЗ-д санал, зөвлөмж өгч ажилладаг болно. Хороо нь ТУЗ-ийн гишүүд, банкны гүйцэтгэх удирдлагатай холбоотой шалгаруулалт, цалин, урамшууллыг зөв зохистой тодорхойлж, тэдний ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнэх, ТУЗ-д санал болгох, зөвлөх зорилго, үүрэгтэй хороо юм.

Тус хороо нь улиралд нэг удаа хуралдах ээлжит хурлын товтой ба энэ нь жилийн эхэнд батлагдаж төлөвлөгддөг. Мөн хэлэлцэх асуудлаас хамаараад тухай бүр ээлжит бус хурал зарлан хуралдуулж ажиллаж байна.

Тайлант хугацаанд Засаглалын хороо нь Гүйцэтгэх удирдлагын багийн ажлын гүйцэтгэлийг Гүйцэтгэх захиралтай хамтран хийж, гэрээний гүйцэтгэлийг хэмжих гол нөхцөлүүдийг шинэчлэн сайжруулж ажилласан. Ингэснээр Гүйцэтгэх удирдлагын томилгоо, хариуцлага, гүйцэтгэлийн үнэлгээ, урамшууллын тогтолцоог цогц хэлбэрээр бүрдүүлэн ажиллаж байна.

Банкны үйл ажиллагаа хөгжиж, бизнесийн цар хүрээ тэлж, зах зээлийн орчин өөрчлөгдөх тусам банкны бүтэц зохион байгуулалт дагаж сайжирч байдаг. Засаглалын хороо нь банкны бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх асуудлыг дэлгэрэнгүй хэлэлцэж, хариуцдаг ба Хорооны зөвлөмжийн дагуу ТУЗ-өөс хэлэлцүүлэн батлуулдаг болно.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, Ёс зүй, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагаанаас нэр дэвшүүлэх үйл ажиллагаатай холбоотой хэсгийг салган Нэр дэвшүүлэх хороог ТУЗ-ийн 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн тогтоолоор 3 гишүүнтэйгээр шинээр байгуулан шинэчилсэн дүрмийг баталсан.

Нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн:

Дарга:

ТУЗ-ийн Хараат бус гишүүн Александр Пикер

Гишүүд:

ТУЗ-ийн дарга Ч.Мөнхцэцэг

ТУЗ-ийн хараат бус гишүүн Роберт В.Ван Свитен

Тус хороо нь банкны Хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангахтай холбоотой дүрэм, журамтай танилцаж, хянан хэлэлцэж зөвлөмжөө өгч ажилладаг. Тиймээс банкны борлуулалт болон төвийн нэгжийн цалингийн систем, тэдгээрийн гүйцэтгэлд суурилсан урамшууллын систем, сонгон шалгаруулах журам, ажилтанд хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох журам, ажилтнуудын халамж тэтгэмжийн журам гэх зэрэг холбоотой бичиг баримтуудтай танилцаж, санал өгдөг. Мөн хүний нөөцтэй холбоотой дараах явцын тайлангуудтай танилцдаг болно. Үүнд:

- Дараа жилийн Хүний нөөцийн төлөвлөгөө, цалин урамшууллын зардлыг энэхүү хороогоор урьдчилан хэлэлцэж, саналаа өгсний дараа нэгдсэн банкны төсөв, төлөвлөгөөнд тусгагддаг болно.
- Хүний нөөцийн удирдах газрын захирлаас хүний нөөцтэй холбоотой гол анхаарал асуудлууд, хийх ажлын төлөвлөгөөтэй танилцдаг.
- Хүний нөөцийн хөдөлгөөн, шилжилт хөдөлгөөний анализ хийж, ирээдүйн төлөвлөгөө, соёлын арга хэмжээнүүдийг авч ажилладаг.

Бодлогын шинэчлэл:

Шинэ стратеги, гадаад орчны өөрчлөлттэй холбогдуулан Голомт банк тайлант хугацаанд томоохон бодлогын бичиг баримтуудаа шинэчиллээ.

- Мэдээллийн технологийн бодлого
- Мэдээллийн аюулгүй байдлын бодлого
- Дата удирдлагын бодлого
- Актив пассивын удирдлагын бодлого
- Хүний нөөцийн удирдлагын бодлого
- Маркетингийн бодлого
- Харилцагч төвтэй банкны бодлого
- Бизнесийн процессын удирдлагын бодлого
- Эрсдэлийн удирдлагын бодлого, эрсдэлийн аппетит бичиг баримт
- Зээлийн бодлого

Бүтэц, зохион байгуулалт:

Банкны үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй явуулахын тулд бүтэц, зохион байгуулалтад дараах сайжруулалтыг хийж, өөрчлөлт оруулав.

1. Дижитал шилжилтийн газар байгуулах;
2. Харилцагчийн бүртгэлийн газар байгуулах;
3. Зээл цуглуулах газар байгуулах;
4. Харилцагчийн үйлчилгээний газар байгуулах;
5. Зээлийн газрын бүтцийг өөрчлөх;
6. Бизнес процесс менежментийн газрыг татан буулгах;

Ингэснээр Голомт банк нийт 19 газартайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Дотоод аудитын үйл ажиллагаа

Дотоод аудиторуд мэргэжлийн ур чадвараа дараагийн түвшинд гаргаж, Олон улсын Дотоод аудитын институтээс олгодог CIA, CEN, CompTIA A+, “IBM data science professional” сертификатыг авснаар Голомт банкны нийт аудиторын 22 хувийг олон улсын цол зэрэгтэй, мэргэшсэн аудитор эзэлж байна.

Голомт банкны дотоод аудитын үйл ажиллагаа нь Олон улсын Дотоод аудиторуудын институт (The Institute of Internal Auditors)-ийн гаргасан Дотоод аудитын мэргэжлийн туршлагын олон улсын хүрээнд нийцсэн бөгөөд үндсэн зорилго нь эрсдэлд суурилсан, хараат бус, бодит баталгаажуулалт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар Банк, түүний нэгж, үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэн нэмэх, стратеги зорилгодоо хүрэхэд нь туслахад чиглэдэг.

Бүтэц, тайлагнал

Голомт банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудитын хороо болон Эрсдэлийн удирдлагын хорооны үйл ажиллагаагаар дамжуулан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлдэг. Банкны нэгжүүд нь эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын тогтолцоогоо бүрдүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар хангах үүрэгтэй байдаг бол Аудитын хороо нь банкны дотоод хяналтын тогтолцооны үр дүнтэй байдалд анхаарч, үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэгтэй. ТУЗ-ийн Аудитын хороо нь тус чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор банкны Гүйцэтгэх удирдлагын багаас хараат бус бүтэцтэй Дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулдаг бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь Аудит хариуцсан захирлыг томилох, Дотоод аудитын үйл ажиллагааны дүрэм, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, стратеги болон жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, эрсдэлд суурилсан аудитын төлөвлөгөө, зардлын төсвийг баталдаг.

Дотоод аудитын үйл ажиллагаа нь Аудит хариуцсан захирлын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Дотоод аудитын газар, Дата анализын алба гэсэн бүтцийн нэгжүүдтэй, 35 ажилтны батлагдсан орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна. Дотоод аудитын газар нь Ерөнхий аудитын хэлтэс, Мэдээллийн технологийн аудитын хэлтэс, Зайны аудит, Чанарын баталгаажуулалтын хэлтсээр дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлдэг.

Голомт банкны Дотоод аудитын үйл ажиллагаа нь 2021 онд Олон улсын нэр хүндтэй байгууллагаар Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт хийлгэж, олон улсын Дотоод аудиторуудын институт (The Institute of Internal Auditors)-ийн Дотоод аудитын мэргэжлийн туршлагын “Олон улсын хүрээ /IPPF/-г бүрэн хангаж байна” гэх сайн үнэлгээ авсан Монгол Улсын анхдагч байгууллага юм. Мөн жил бүр дотоод чанарын баталгаажуулалтыг хийж, Дотоод аудитын мэргэжлийн туршлагын Олон улсын хүрээ /IPPF/-г хангах, үйл ажиллагааг нийцүүлэх ажлыг хийж байна.

Хамрах хүрээ, аргачлал

Дотоод аудитын үйл ажиллагаа нь эрсдэлд суурилсан аргачлал ашигладаг бөгөөд улирал бүр банкны бизнес төлөвлөгөө, нэгж, үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, үр дүнд үндэслэн аудитын төлөвлөгөө болон хамрах хүрээг тодорхойлж байна.

Банк нь стратеги зорилтууддаа хүрэх, тодорхойлсон эрсдэлийн аппетитынхаа хүрээнд үйл ажиллагаагаа явуулахад банкны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо хангалттай, үр дүнтэй байгаа эсэхийг Дотоод аудитын газар үнэлж, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж хүргүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар банкны үйл ажиллагаанд үнэ цэн нэмж байна. Зөвлөх үйлчилгээг банкны менежментийн багийн хүсэлтээр хийдэг бөгөөд засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор, удирдлагын болон гүйцэтгэх чиг үүрэг хүлээлгүйгээр банкны нэгж, үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.

Дотоод аудитын үйл ажиллагаа

- Дотоод аудитын үйл ажиллагаа нь дотоод чанарын баталгаажуулалт хийдэг бүтцийг бий болгож, чанарын баталгаажуулалт, сайжруулах хөтөлбөрт байнгын хяналт хийж, дүгнэлт өгдөг, үйл ажиллагааг сайжруулах, олон улсын сайн туршлагатай нийцүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, үйл ажиллагааг тасралтгүй сайжруулж байна.
- Дата анализын тусламжтайгаар аудитын үйл ажиллагааг дэмжих, аудитын аргачлалыг сайжруулах, аудитын хамрах хүрээ, зорилгыг оновчтой тодорхойлох, аудитын нөөцийг хэмнэхэд чиглэсэн дашбоард, сэжигтэй гүйлгээний анализын тайлан, эрсдэлийн үнэлгээний автоматжуулалт, RPA / robotic process automation/ хөгжүүлэлтүүд хийж, аудитын үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.
- Дотоод аудитын үйл ажиллагаа нь 2023 онд аудит хийхдээ сайн засаглалын зарчмуудын хэрэгжилт, банкны стратеги төлөвлөгөөний гүйцэтгэл, шинэ тутам бий болж буй эрсдэлд төвлөрч ажилласан. Мөн гадны байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлж мэдлэг, туршлагаа хуваалцсан нь Голомт банкны Дотоод аудитын үйл ажиллагааг сурталчилсан үйл явдал болов.
- Дотоод аудиторуд мэргэжлийн ур чадвараа дараагийн түвшинд гаргаж, Олон улсын Дотоод аудитын институтээс олгодог CIA /Certified Internal Auditor/ цолыг шинээр 1 аудитор, CEH /Certified Ethical hacker/, CompTIA A+ /The Computing Technology Industry Association/, "IBM data science professional certificate" мэргэшлийн сертификатыг тус бүр 1 аудитор авч, нийт аудиторын 22 хувийг олон улсын цол зэрэгтэй, мэргэшсэн аудитор эзэлж байна.

Удирдлагын баг



Норихико Като
Гүйцэтгэх захирал



Г.Ганболд
Ерөнхийлөгч



А.Одонбаатар
Гүйцэтгэх захирлын
орлогч



М.Сайнбилэг
Мэдээллийн технологи
хариуцсан захирал



С.Мөнхтуяа
Санхүүгийн удирдлагын
газрын захирал



М.Наранхүү
Зээлийн газрын захирал



Т.Отгон
Эрсдэлийн удирдлагын
газрын захирал



Б.Содболор
Нөөцийн удирдлагын
газрын захирал



Ц.Байгалмаа
Иргэдийн банкны газрын
захирал



Б.Сугар-Эрдэнэ
Байгууллагын банкны
газрын захирал



А.Ганчимэг
Байгууллага хөгжлийн
газрын захирал



Б.Учрал
Дижитал банкны газрын
захирал



Г.Уянга

Хүний нөөцийн удирдлагын
газрын захирал



Н.Очирхуяг

Маркетинг, олон нийттэй
харилцах газрын захирал



Б.Энхзаяа

Олон улсын банкны
газрын захирал



О.Батцэнгэл

Мэдээлэл технологийн
газрын захирал



Ж.Оюун

Дижитал шилжилтийн
газрын захирал



Ё.Пүрэвбат

Бүртгэл тооцооны газрын
захирал



Г.Мандах

Харилцагчийн бүртгэлийн
газрын захирал



Х.Пүрэвдорж

Захиргааны газрын
захирал



А.Нямсүрэн


Харилцагчийн үйлчилгээний
газрын захирал




Б.Энхтүвшин


Зээл цуглуулах газрын
захирал


Бүтэц, зохион байгуулалт





Эдийн засаг, санхүүгийн тойм





Эдийн засаг, санхүүгийн тойм

Татварын дараах
цэвэр ашиг

209.2

тэрбум төгрөг

Монгол Улс 2023 онд 66.7 сая тонн коксжих нүүрс экспортолж, түүхэн дээд хэмжээг эвдлээ. Ингэснээр эдийн засгийн өсөлт 7.0%-д хүрч, төлбөрийн тэнцэл 1.46 тэрбум ам.долларын ашигтай гарснаар эдийн засгийн бүх үзүүлэлт харьцангуй эерэг гарлаа. Эдийн засгийн өсөлт өндөр, төлбөрийн тэнцлийн ашгаар өдөөгдсөн мөнгөний нийлүүлэлт өндөр байсан нь банкны салбарын ашигт ажиллагаанд нөлөөлж, Голомт банкны татварын дараах цэвэр ашиг 209.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оноос 80% өссөн үзүүлэлт юм.


Эдийн засгийн тойм

Дэлхийн эдийн засгийн орчинд тодорхой бус байдал өндөр байгаа ч Монгол Улсын хувьд 2023 он эдийн засгийн болон олон улсын харилцаа таатай байж, зээлжих зэрэглэлээ тогтвортой В түвшиндээ хэвээр хадгалж, бодит эдийн засаг оны эцэст 7%-аар өслөө.

Дэлхийн эдийн засаг 2023 онд 3.1% өссөн ч энэ нь түүхэн дундаж өсөлт 3.8% (2000 он - 2019 он)-аас бага байна. Холбооны нөөцийн сан, Европын төв банк зэрэг дэлхийн томоохон төв банкнууд 2023 оны турш мөнгөний хатуу бодлого баримталж, цар тахлын дараах өндөр инфляцтай тасралтгүй тэмцлээ. Үр дүнд нь инфляц алгуур буурч, төв банкнуудын зорилтот түвшин рүү дөхөж байгаа ч дэлхийн улс орнуудын, тэр дундаа хөгжиж буй орнуудын эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрэх нь хол байгааг “Дэлхийн эдийн засгийн төлвийн тайлан”-даа ОУВС дурджээ.



Бодит эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хэдийгээр дэлхийн эдийн засгийн орчинд тодорхой бус байдал өндөр байгаа ч манай улсын хувьд 2023 он эдийн засгийн болон олон улсын харилцаа таатай байж, зээлжих зэрэглэлээ тогтвортой В түвшиндээ хэвээр хадгалж, бодит эдийн засаг оны эцэст 7%-аар өслөө.

БНХАУ-ын хилийн боомтууд бүрэн нээгдсэнээс хойш экспорт эрчимтэй өсөж, нүүрсний экспорт түүхэн дээд хэмжээнд буюу 66.7 сая тонн (коксжих нүүрс) хүрсэн нь эдийн засгийн идэвхжилийг голлон дэмжлээ. Гэсэн хэдий ч манай улсын худалдааны гол түнш БНХАУ-ын үл хөдлөх салбарын уналт нь эдийн засгийн өсөлтийг удаашруулах хүлээлттэй байгаа нь экспортын түүхий эдийн эрэлт болон үнэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Түүнчлэн Монголбанк энэ оны турш бодлогын хүүг 13%-ийн өндөр түвшинд хэвээр хадгалж байгаа нь зээлийн хүү, санхүүжилтийн өртгийг нэмэгдүүлж бизнесийн салбарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул макро эдийн засгийн зохистой бодлого хэрэгжүүлэх нь 2024 оны эдийн засгийн төлөвт чухал байна.

Эдийн засгийн өсөлт /салбараар/




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдийн засгийн засгийн өсөлтийг салбараар авч үзвэл, нүүрс, зэсийн баяжмал, газрын тосын олборлолт сайжирснаар уул уурхайн салбарын өсөлт 2023 онд 23.4%-д хүрч өсжээ. Энэ нь зам, тээврийн салбарын өсөлтийг үнэмлэхүй дэмжлээ. Тухайлбал зам, тээврийн салбар 2023 онд нийт 107.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оноос 76.6%-аар өсөж, тээвэрлэсэн нийт ачааны 87.6%-ийг уул уурхайн салбарын бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна. Түүнчлэн 2023 онд шинэ үүрэн холбооны операторын үйл ажиллагаа тэлснээр мэдээлэл, харилцаа холбооны салбарын өсөлт 16.7%-д хүрсэн байна.

2023 оны хүйтэн, ган зуд ихтэй жил ХАА-н салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлж, тус салбар 8.9%-ийн уналттай байна. Тухайлбал, 2023 оны байдлаар хорогдсон малын тоо 4.9 сая толгойд хүрч, хорогдлын хувь 7.5% болжээ. Энэ нь 2022 оны малын хорогдлын тоотой харьцуулахад 7.4 дахин өссөн үзүүлэлт юм. Малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл, хонь 2,174.2 мянга, ямаа 2,053.3 мянга, үхэр 415.5 мянга, адуу 269.7 мянга, тэмээ 8.8 мянган толгойгоор тус тус хорогдсон байна. Нийт хорогдсон малын 41.7 хувийг ямаа, 44.2 хувийг хонь эзэлж байна.


Бодлогын хүү ба инфляц



Улсын инфляц 2023 оны эцэст 7.9%-д хүрч, Монголбанкны инфляцын зорилтот түвшин болох 6% (+-2) интервалд хүрлээ. 2022 оны 2-р улиралд 16.9%-д хүрээд байсан инфляц үүнээс хойш алгуур буурч, 2023 оны эцэст 7.9%-д хүрсэн нь төв банкны мөнгөний хатуу бодлого 2023 оны турш үргэлжилсэн, түүхий эдийн үнэ олон улсын зах зээл дээр буурсан зэрэг нь голлон нөлөөллөө.

Харин ирэх онд инфляц эрэлтийн шалтгаантай нэмэгдэх хүлээлттэй байгаа бөгөөд 2024 оны алдагдалтай батлагдсан төсөв нь хэт өөдрөг төсөөлөлтэй төсвийн орлого зорилтот түвшиндээ хүрэхгүй байх, төсвийн зардал нэмэгдэх зэрэг эрсдэлүүд болон хүлээгдэж буй цалин, тэтгэврийн өсөлт зэргээс хамаарч инфляцад үзүүлэх дарамт нэмэгдэхээр байна.

Төлбөрийн тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Төлбөрийн тэнцэл 2022 онд 727 сая ам.долларын алдагдалтай байсан бол 2023 оны гүйцэтгэлээр 1,457 сая ам.долларын ашигтай гарлаа. Сүүлийн 16 жил алдагдалтай байсан урсгал данс 2023 онд 244.5 сая ам.долларын ашигтай гарлаа. Урсгал данс ашигтай гарахад бараа худалдааны экспорт нэмэгдэж, барааны худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан нь нөлөөлсөн бол үйлчилгээний худалдааны тэнцэл 2.7 тэрбум ам.долларын алдагдалтай гарч алдагдал өмнөх оноос 11%-аар өсжээ.

Харин санхүүгийн дансны тэнцэл 2023 онд 1.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оноос 16%-аар буурчээ. Санхүүгийн дансны ашиг буурахад гадаадын шууд хөрөнгө оруулалт 2023 онд өмнөх оноос 29.4%-аар буурч, багцын хөрөнгө оруулалт дансны урт хугацаат зээлийн эргэн төлөлт 413 сая ам.доллараар өссөн нь тус тус нөлөөлсөн байна.

Гадаад валютын албан нөөц, нүүрсний биет хэмжээ




Эх сурвалж: Монголбанк

Манай улс 2023 онд 66.7 сая тонн коксжих нүүрс экспортолсон нь түүхэн дээд хэмжээ төдийгүй өмнөх оноос 2 дахин нэмэгджээ. Түүнчлэн 2023 онд Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль батлагдаж, 7-р сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн. Уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр дамжуулан арилжаалах эрх зүйн орчин ийнхүү бүрдсэн нь энэ салбарт гарсан онцлох үйл явдал байлаа. Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг биржээр дамжуулан нээлттэй, ил тод, шударга зохион байгуулж, зах зээлийн бодит үнэ тогтох боломж бүрдүүлэх нь эдийн засгийн өсөлтөд салбарын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх боломж юм.

Харин гадаад валютын албан нөөц өмнөх оноос 1,519 сая ам.доллараар өсөж, 2023 онд 4,918 сая ам.долларт хүрлээ. Валютын нөөц ийнхүү хуримтлагдаж байгаа нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарахад голлон нөлөөлж, оны эцэст төгрөг ам долларын эсрэг 1%-аар чангараад байна.

Төсвийн зардал

Төсвийн зардал нэмэгдсэнээр мөнгөний хатуу бодлогын нөлөө саарч, инфляц хөөрөгдөх эрдсэлийг үүсгэв.




Эх сурвалж: Сангийн яам

2023 оны 6-р сард төсвийн тодотголоор эдийн засгийн сэргэлт эрчимжиж байгаатай холбогдуулан төсвийн зардлыг 1.9 их наяд төгрөгөөр өсгөж 22.4 их наяд төгрөгт хүргэх шийдвэр гарсан. Ийнхүү төсвийн зардал, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин хөлсний зардал нэмэгдсэнээр мөнгөний хатуу бодлогын нөлөө багасаж, инфляц 8-р сараас эхлэн эргэн хөөрөгдөж эхэлсэн. Харин жилийн эцэст суурийн нөлөө болон олон улсын зах зээлд түүхий эдийн үнэ буурч, нийлүүлэлтээр дамжсан инфляцын нөлөө багасаж, жилийн эцэст инфляц 7.9%-тай гарсан байна.

Цаашлаад төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2023 оны эцэст 23.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 (34.8%) их наяд төгрөгөөр өссөн бол улсын төсвийн зардал 22.5 их наяд хүрч жилийн өмнөхөөс 4.3 (23.6%) их наяд төгрөгөөр өссөн байна. 2024 онд төсвийн зардал 27.4 их наяд төгрөгт хүрэх хүлээлттэй байгаа нь 2024 онд инфляцын хөөргөдлөөс сэргийлэн мөнгөний хатуу бодлого үргэлжлэх дохио болж буй юм.

Өрхийн орлого, зардал

Өрхийн орлого өмнөх оны мөн үеэс 23.8%, өрхийн зардал 22.7%-аар өсжээ.



Эх сурвалж: Монголбанк

2023 оны төсвийн тодотголоор төрийн албан хаагчдын цалин болон тэтгэвэр тэтгэмж нэмэгдэж, үүнийг дагаад хувийн хэвшлийн ажилчдын цалин өссөн билээ. Тиймээс 2023 оны эцэст өрхийн сарын дундаж орлого 2.3 сая төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23.8 хувиар өссөн байна. Өрхийн орлого ийнхүү өсөхөд цалин хөлсний орлого 260.8 мянгаар буюу өмнө оны мөн үеэс 28 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Цаашлаад үнийн нөлөөг арилган тооцсон өрхийн бодит сарын дундаж орлого 1.3 сая төгрөг болж өмнө оны мөн үеэс 14.1 хувиар өсжээ.

Нэрлэсэн өрхийн зардал оны эцэст 2.2 сая төгрөг хүрч өмнө оны мөн үеэс 22.7 хувиар өссөн байна. Ийнхүү өсөхөд хүнсний бус бараа, үйлчилгээний зарлага 285.2 мянгаар буюу 2022 оны эцэстэй харьцуулахад 24.1 хувиар нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Цаашлаад үнийн нөлөөг арилган тооцсон бодит зардал 1.3 сая төгрөг болж, өмнө оны мөн үеэс 13.2 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

2023 оны эцэст инфляцын нөлөөг арилган тооцсон бодит зардлын өсөлт харьцангуй удааширсан бол бодит орлогын өсөлт тогтвортой байсан нь харагдаж байна.

Бондын эргэн төлөлт ба зээлжих зэрэглэл

2023 онд Хөгжлийн банкны Самурай болон Евро бондын 700 сая ам.доллар, Гэрэгэ бондын үлдэгдэл 387 сая ам.долларын өрийг бүрэн төлж барагдуулжээ. 2023 онд төлөгдөх ёстой байсан БНХАУ-ын SWAP хэлцлийн 2 тэрбум ам.долларын төлөлтийг 2026 он хүртэл хойшлуулж, 2024 онд төлөгдөх хүлээлттэй байсан Хуралдай бондын 600 сая ам.долларын төлөлтийг дахин санхүүжүүлэхээр 2029 онд төлөх 7.875 хувийн хүүтэй, 350 сая ам.долларын “Зуун 3” бонд гаргаснаар 2026 он хүртэл өр төлбөрийн дарамт багассан аж. Дэлхийн томоохон зээлжих зэрэглэл тогтоогч S&P, Fitch, Moody's байгууллагуудаас Монгол Улсыг В тогтвортой зэрэглэлд хэвээр үлдээжээ.

Банкны салбар

2023 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын нийт зээлийн 4.7% буюу 1,264.0 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 7.5% буюу 2,032.1 тэрбум төгрөгийн зээл чанаргүй зээлийн ангилалд багтаж байна. Нийт зээлийн хэмжээ 27.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 23.3%-аар өссөн бол банкны системийн чанаргүй зээлийн хувь 7.5% хүрч буурлаа. Ийнхүү буурахад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт хүлээгдэж байснаас нэмэгдэж эдийн засгийн идэвхжлийг дэмжсэн нь голлон нөлөөллөө.

Бодлогын хүү өндөр хэвээр хадгалагдаж байгаа учраас хадгаламж, зээлийн хүү алгуур өсөж, төгрөгийн зээлийн хүү 16.7%-д, хадгаламжийн хүү 11.6%-д хүрлээ.




Банкны салбарын гүйцэтгэл

Үзүүлэлтүүд	Нэгж	2021	2022Н1	2022	2023Н1	2023	Өсөлт
Нийт актив	тэрбум ₮	40,936	42,108	45,956	47,998	57,070	24.2%
Нийт зээлийн үлдэгдэл	тэрбум ₮	20,667	23,251	22,008	25,355	27,144	23.3%
Хугацаа хэтэрсэн зээл	тэрбум ₮	932	1,099	1,123	1,317	1,264	12.5%
Чанаргүй зээл	тэрбум ₮	2,073	2,095	2,019	2,207	2,032	0.7%
Чанаргүй зээлийн харьцаа	%	10.03%	9.01%	9.17%	8.70%	7.49%	-18.4%
Иргэдийн зээл, ₮	тэрбум ₮	10,328	11,954	11,492	13,748	15,305	33.2%
Иргэдийн зээл, \$	тэрбум ₮	63	62	63	70	70	10.6%
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	177	285	269	295	264	-2.0%
Хугацаа хэтэрсэн зээл, Иргэд, \$	тэрбум ₮	3	1	1	0	2	170.1%
Чанаргүй зээл, Иргэд, ₮	тэрбум ₮	472	422	479	477	479	-0.1%
Чанаргүй зээл, Иргэд, \$	тэрбум ₮	22	22	22	22	24	8.6%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, ₮	%	4.57%	3.53%	4.17%	3.47%	3.13%	-25.0%
Чанаргүй зээлийн харьцаа, Иргэд, \$	%	34.92%	35.64%	34.80%	31.33%	34.16%	-1.8%
Байгууллагын зээл, ₮	тэрбум ₮	8,821	9,910	9,236	10,058	10,179	10.2%
Байгууллагын зээл, \$	тэрбум ₮	1,454	1,324	1,218	1,479	1,590	30.6%
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	453	547	691	687	620	-10.3%
Хугацаа хэтэрсэн зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	299	265	163	334	379	132.2%
Чанаргүй зээл, Байгууллага, ₮	тэрбум ₮	1,433	1,475	1,367	1,557	1,371	0.4%
Чанаргүй зээл, Байгууллага, \$	тэрбум ₮	146	176	151	151	158	4.5%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, ₮	%	16.24%	14.88%	14.80%	15.48%	13.47%	-8.9%
Чанаргүй зээлийн харьцаа, Байгууллага, \$	%	10.05%	13.31%	12.43%	10.17%	9.95%	-20.0%
Нийт харилцах хадгаламж	тэрбум ₮	26,772	26,620	28,601	30,391	36,503	27.6%
Харилцах данс, ₮	тэрбум ₮	5,634	5,293	6,369	7,455	8,947	40.5%
Харилцах данс, \$	тэрбум ₮	2,339	3,232	4,907	3,541	5,619	14.5%
Хадгаламж, ₮	тэрбум ₮	14,826	13,568	12,415	14,199	16,938	36.4%
Хадгаламж, \$	тэрбум ₮	3,973	4,526	4,910	5,196	4,999	1.8%
Өөрийн хөрөнгө	тэрбум ₮	4,013	4,655	4,979	5,528	6,182	24.2%
Нийт пассив	тэрбум ₮	36,923	37,453	40,977	42,470	50,887	24.2%

Эх сурвалж: Монголбанк

M2 мөнгөний жилийн өсөлт, түүний бүрэлдэхүүн

Мөнгөний нийлүүлэлтийн хэмжээ өмнө оны мөн үетэй харьцуулахад 27%-аар өсөж, 37.6 их наяд төгрөгт хүрлээ.



Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2023 оны 12-р сарын эцэст 37.6 их наяд төгрөг болж, өмнөх оноос 7.9 (26.8%) их наяд төгрөгөөр өсжээ. Төгрөгийн ам.доллартой харьцах ханш чангарснаар төгрөг хадгалах хандлага ихсэж, улмаар төгрөгийн харилцах 2.6 (40.5%) их наяд төгрөгөөр, төгрөгийн хадгаламж 4.5 (35.7%) их наяд төгрөгөөр өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

2023 оны эхээс БНХАУ-ын хил, гаалийн хорио бүрэн зогссоноор нүүрсний экспорт үнэмлэхүй өссөн. Ийнхүү 2022 оны турш алдагдалтай байсан төлбөрийн тэнцэл 2023 оны эцэст 1.5 тэрбум ам.доллар буюу ойролцоогоор 5.1 их наяд төгрөгийн ашигтай гарснаар мөнгөний нийлүүлэлт өсөх гол шалтгаан болжээ.

Мөн Ипотекийн зээл олголт 2023 оны эхээс хэвийн явагдаж эхэлсэн ба банкны эх үүсвэрээр 10 хувийг, Монголбанкны санхүүжилтээр 90 хувийг олгох болжээ. Үүний үр дүнд зах зээлд мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн ба 2022 онд ипотекийн зээлийн үлдэгдэл 6.5 их наяд төгрөг байсан бол 2023 оны эцэст 17.8 хувиар нэмэгдэж 7.6 их наяд төгрөг хүрчээ.


Цаашлаад системийн нөлөө бүхий банкнууд IPO амжилттай хийж 444 тэрбум орчим төгрөгийг татан төвлөрүүлснээр зээл олголт нэмэгдэж үржүүлэгчийн нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлт нэмэгдэх нэг хүчин зүйл болжээ.

Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2023 оны 12 сард 23.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6 (34.8%) их наяд төгрөгөөр өссөн бол улсын төсвийн зардал 22.5 их наяд хүрч жилийн өмнөхөөс 4.3 (23.6%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн нэмэгдүүлэх бас нэг томоохон суваг нь гадаад улсуудаас орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт болон өр зээлийн урсгал билээ. 2023 оны эхний 3 улиралд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 1.87 тэрбум ам.доллар буюу ойролцоогоор 6.4 их наяд төгрөгт хүрчээ. Харин гадаад өр 2023 оны 3-р улирлын байдлаар 34 тэрбум ам.долларт хүрч 2022 оны эцэстэй харьцуулахад 400 сая ам.доллар буюу ойролцоогоор 1.4 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төгрөгийн харилцах, хадгаламжийн өсөлт долларын харилцах, хадгаламжийн өсөлтийг давж, долларжилт багасаж байна.

Ханш болон харилцах, хадгаламжийн дүн



Эх сурвалж: Монголбанк


2023 онд гадаад худалдааны нөхцөл байдал сайжирснаар валютын орох урсгал нэмэгдэж, төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3-р сарын дунд үеэс чангарч эхэлсэн байна. Оны эцсийн байдлаар гадаад валютын албан нөөц 4.9 тэрбум ам.долларт хүрч, ханшийн хувьд 3-р сарын дунд үед нэг ам.долларт оргил үедээ 3'528 төгрөг ногдож байсан бол 12-р сарын 31-ний байдлаар 3'410 төгрөг болжээ.

Төгрөгийн ханш чангарснаар долларжих үзэгдэл багасаж, төгрөгийн харилцах, хадгаламжийн өсөлт нэмэгдсэн бол валютын хадгаламжийн өсөлт саарчээ. Харин валютын харилцах дансны өсөлтийн хувь хэлбэлзэл өндөртэй байна.

Оргил үедээ тус тус 124 хувь, 39 хувийн өсөлттэй байсан валютын харилцах, хадгаламжийн өсөлт 2023 оны эцэст 14 хувь, 2 хувь болж саарсан үзүүлэлттэй гарчээ. Харин төгрөгийн харилцах, хадгаламж оны эцэст тус тус 40 хувь, 36 хувийн өсөлттэй гарсан байна.

Зээлийн хэмжээ болон жилийн өсөлтийн хувь /сегментээр/

Иргэдийн зээлийн өсөлт байгууллагын зээлийн өсөлтөөс өндөр байна.



Эх сурвалж: Монголбанк

Манай улсын эдийн засаг идэвхжиж он гарснаас хойш зээл олголт нэмэгдэж, иргэд болон байгууллагын зээлүүд өсөлттэй байлаа. 2023 оны эцэст иргэдийн зээлийн өсөлт 33.1%-д хүрсэн бол байгууллагын зээлийн өсөлт 12.6% хувь байна. Бизнесийн зээлийн өсөлт саарч байгаа нь бодит эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй.

Иргэдэд олгосон шинэ зээл /ангиллаар/


Хэрэглээний зээлд багтах цалин, тэтгэврийн зээл хамгийн өндөр өсөлттэй байна.



Эх сурвалж: Монголбанк

Дижитал зээлийн үйлчилгээ тэлснээр цалин, тэтгэврийн зээл авах хандлага нэмэгдэж хэрэглээний зээлийн хэмжээ өссөн үзүүлэлттэй байна. Хэрэглээний зээл 2022 онтой харьцуулахад 40 хувиар өсчээ. Картын зээл өмнө жилтэй харьцуулахад багассан бол автомашин, өрхийн хэрэглээ, малчин, хадгаламж барьцаалсан зээлүүд өмнөх оноос өсчээ.

Банкнудын жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Монголбанк

Бодлогын хүү өндөр хэвээр хадгалагдаж байгаа учраас хадгаламж, зээлийн хүү алгуур өссөн үзүүлэлттэй байна. Шинээр олгосон төгрөгийн зээл, хадгаламжийн хүүний зөрүү оны эцэст 5.1%-д хүрч, өмнөх оны мөн үеэс 0.3%-аар өсжээ. Үүнд, төгрөгийн зээлийн хүү өмнөх оны эцсээс 1%-аар өсөж, 16.7%-д хүрсэн бол хадгаламжийн хүү 0.7%-аар өсөж, 11.6%-д хүрсэн байна.

Харин валютын зээлийн хүү, хадгаламжийн хүүнээс бага хувиар өссөн байна. Тухайлбал, тухайн сард шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү 2023 онд 0.8%-аар өсөж, 4.2%-д хүрсэн бол гадаад валютын зээлийн хүү оны эхнээс 0.3%-аар өсөж, 12 сард 10.5%-д хүрчээ. Ийнхүү гадаад валютын зээлийн хүү болон хадгаламжийн хүүний зөрүү 2023 оны эцэст 6.3% байна.


Байгууллагуудад олгосон шинэ зээл /салбараар/



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн өсөлтийг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзвэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээний салбарын зээлийн олголт 65.3%-аар буюу 2.8 их наяд төгрөгөөр өсч 7.1 их наяд төгрөгт хүрчээ. Харин боловсруулах үйлдвэрлэлийн зээл 60.5%-аар өсч 2.5 их наяд төгрөгт, барилгын салбарын зээл 33.5%-аар өсч 1.8 их наяд төгрөгт хүрчээ. Харин өнгөрсөн жил 24.5%-ийн өсөлттэй байсан худалдааны салбарын зээл энэ онд 12.3%-аар өсчээ. Уул уурхайн салбарын зээл 11%-аар буюу 241 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Чанаргүй зээлийн өөрчлөлтийн хувь



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн чанаргүй зээлийн хэмжээ 2022 онд 2,019 тэрбум төгрөг байсан бол 2023 оны эцэст 2,032 тэрбум төгрөг болж өмнөх оноос 0.7%-аар өссөн байна. Цаашлаад нийт зээлийн хэмжээ өссөнөөр нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 7.5% болж буурчээ. Өнгөрсөн онд эдийн засгийн өсөлт 7%-д хүрч, өрхийн хэрэглээ сэргэж, бизнесийн байгууллагуудад эерэгээр нөлөөлсөнтэй холбоотой үйлчилгээний салбарын чанаргүй зээл хамгийн их хувиар буюу 8.9%-аар буурсан байна. Харин худалдааны салбарын чанаргүй зээлийн хэмжээ хамгийн их буюу 27%-аар өсжээ.

Голомт банкны санхүүгийн үр дүн

Банкны нийт актив өмнөх оноос 2.6 их наяд төгрөгөөр буюу 29.4 хувиар өсөж, 11.6 их наяд төгрөгт хүрснээр зах зээлд эзлэх хувь 20.1% болж өслөө.

2023 оны нөхцөл байдал

- 2023 онд уул уурхайн салбарын сэргэлтийн нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг 7 хувиар өсөв.
 - Гадаад валютын албан нөөц нэмэгдэж, 4.9 тэрбум ам.долларт хүрснээр төгрөгийн ам.доллартой харьцах ханш тогтвортой байв. Оны эцэст ам.долларын ханш 3,410.7 төгрөгт хүрлээ.
 - 2023 онд инфляцын эрсдэлээс хамгаалан бодлогын хүүг Монголбанкны 4 удаагийн шийдвэрээр 13.0 хувь буюу өндөр хэвээр хадгалав. Улмаар инфляцын түвшин 7.9 хувьд хүрч буураад байна.
-

2023 оны санхүүгийн гол амжилтууд


- Нийт зээлийн хэмжээ 25.2 хувиар өсөж, 4.9 их наяд төгрөгт, харилцагчдын эх үүсвэр 39.9 хувиар өсгөж, 8.0 их наяд төгрөгт хүрэв. Банкны салбарын зах зээлд эзлэх хувь нийт зээлийн хэмжээгээр 17.5%, харилцагчийн эх үүсвэрийн хэмжээгээр 20.0%-д тус тус хүрч өсөв.
 - Активын чанарын удирдлагыг амжилттай хэрэгжүүлснээр чанаргүй зээлийн харьцааг 5.0 хувьд хүргэж бууруулсан ба банкны системийн чанаргүй зээлийн хувиас доогуур буюу сайн үзүүлэлттэй байна.
 - 2023 оны татварын дараах цэвэр ашиг өмнөх оноос 79.5 хувиар өсөж, 209.2 тэрбум төгрөгт хүрлээ. Мөн цэвэр хүүгийн ахиуц харьцаа 6.5 хувьд хүрч, өөрийн хөрөнгийн өгөөж 24.1 хувьд хүрч сайжрав. Нэгж хувьцаанд ногдох ашиг 258.66 төгрөгт хүрч өслөө.
-

Санхүүгийн үр дүн

Нийт актив өмнөх оны эцэстэй харьцуулахад 29.4 хувиар өсөж 11.6 их наяд төгрөгт, харилцагчийн эх үүсвэр 39.9 хувиар өсөж 8.0 их наяд төгрөгт хүрээд байна.

Нийт хөрөнгө

тэрбум төгрөг




11,628

тэрбум төгрөг

Харилцах, хадгаламж

тэрбум төгрөг



8,037

тэрбум төгрөг


Санхүүгийн үр дүн

Голомт банк гадаадын банк санхүүгийн байгууллагуудтай идэвхтэй хамтын ажиллагаагаа үргэлжлүүлж, шинээр 45 сая ам.долларын зээл татаж, баланс үйл ажиллагаагаа тэлж ажиллалаа.

2023 онд банкны өөрийн хөрөнгө 24.3 хувиар өсөж, 1,071.1 тэрбум төгрөгт хүрлээ. 2023 оны эцсээр Голомт банкны нэгж хувьцаанд ногдох ашиг 258.66 төгрөгт хүрч, өмнөх оны эцэстэй харьцуулахад 58.0 хувийн өсөлтийг үзүүлээ.

Бусад эх үүсвэр

тэрбум төгрөг




2,254

тэрбум төгрөг

Өөрийн хөрөнгө

тэрбум төгрөг




1,071

тэрбум төгрөг

2023 онд банк цэвэр зээлийн багцаа 27.4 хувиар өсгөхийн зэрэгцээ активын чанарын удирдлагыг хэрэгжүүлж чанаргүй зээлийн харьцааг 5.0 хувьд хүргэн сайжрууллаа. Хөрөнгө оруулалтын багц 91.9 хувиар өсөж, 2.4 их наяд төгрөгт хүрлээ.

Цэвэр зээл

тэрбум төгрөг




4,712

тэрбум төгрөг

Хөрөнгө оруулалт

тэрбум төгрөг



2,404

тэрбум төгрөг

Ашигт ажиллагаа

Голомт банк 2023 онд 209.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд үйл ажиллагааны ашиг (свопын нөлөөгүйгээр) 387.4 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оноос 22.1 хувиар өссөн байна. 2023 онд бодлогын хүү өндөр хэвээр хадгалагдсантай холбоотой 2023 оны эцсийн байдлаар хүүгийн орлого өмнөх оноос 37.8 хувиар, цэвэр хүүгийн орлого 23.8 хувиар өсөж, 477.3 тэрбум төгрөгт хүрч, цэвэр хүүгийн ахиуц харьцаа 6.5 хувьд хүрч сайжирлаа.

Цэвэр ашиг

тэрбум төгрөг



Үйл ажиллагааны ашиг

тэрбум төгрөг



Банкны үйл ажиллагааны зардал 14.2 хувиар өсөж, 200.2 тэрбум төгрөгт хүрсэн бол сан үнэлгээний зардал өмнөх онтой харьцуулахад буурч, 12 тэрбум төгрөгийн сан буцаасны цэвэр орлоготой гарсан нь ашгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээд байна.

Үйл ажиллагааны зардал

тэрбум төгрөг



Сан үнэлгээний зардал

тэрбум төгрөг



Зохистой харьцаа (Монголбанкны тайлангаар)

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, зээлийн төвлөрөл, төлбөрийн чадвар, гадаад валютын эрсдэлтэй холбоотой үзүүлэлтээр Монголбанкнаас тавьдаг шалгуурыг бүрэн хангаж ажиллаа.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ



Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар




Голомт банкны 5 жилийн санхүүгийн үр дүн

Санхүүгийн үзүүлэлтүүд	2019	2020	2021	2022	2023
Балансын үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)					
Нийт актив	6,643	7,278	7,994	8,985	11,628
Харилцах, хадгаламж	4,901	5,286	5,464	5,743	8,037
Бусад эх үүсвэр	994	1,237	1,748	2,180	2,254
Цэвэр зээл	3,307	3,031	3,339	3,698	4,712
Нийт өөрийн хөрөнгө	635	632	659	862	1,071
Орлогын тайлангийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)					
Хүүгийн орлого	578	570	555	610	841
Хүүгийн зардал	(366)	(366)	(273)	(224)	(363)
Цэвэр хүүгийн орлого	212	204	282	386	477
Цэвэр хүүгийн бус орлого	81	83	49	142	(24)
Үйл ажиллагааны орлого	293	287	331	527	454
Үйл ажиллагааны зардал	(122)	(121)	(137)	(175)	(200)
Үйл ажиллагааны ашиг	171	166	193	352	254
Үйл ажиллагааны ашиг - Свопын нөлөөгүй	156	151	215	317	387
Сан, үнэлгээний зардал	(146)	(143)	(141)	(158)	12
Татварын өмнөх ашиг	25	22	53	194	266
Татварын зардал	(9)	(12)	(27)	(77)	(57)
Татварын дараах ашиг	16	10	26	117	209
Санхүүгийн бүтцийн харьцаанууд					
Нийт харилцах, хадгаламж / Нийт актив (%)	73.8%	72.6%	68.3%	63.9%	69.1%
Бусад эх үүсвэр / Нийт актив (%)	15.0%	17.0%	21.9%	24.3%	19.4%
Цэвэр зээл / Нийт актив (%)	49.8%	41.7%	41.8%	41.2%	40.5%
Чанаргүй зээлийн харьцаа (%)*	5.0%	8.4%	7.6%	6.9%	5.0%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ (%)*	78.6%	71.9%	72.5%	96.4%	106.2%
Ашигт ажиллагааны харьцаанууд					
Дундаж активын өгөөж (%)	0.3%	0.2%	0.3%	1.4%	2.2%
Дундаж ӨХ-н өгөөж (%)	3.3%	2.5%	5.1%	19.5%	24.1%
Цэвэр хүүгийн ахиуц (%)	4.2%	4.0%	4.6%	5.9%	6.5%
Зардал, орлогын харьцаа (%)	41.7%	42.2%	41.5%	33.3%	44.1%
Зохистой харьцааны үзүүлэлтүүд*					
ӨХ-н хүрэлцээ >12%	13.5%	14.2%	13.3%	17.6%	15.9%
1-р зэрэглэлийн ӨХ хүрэлцээ >9% (нөөц +4%)	9.0%	13.7%	13.0%	17.6%	15.9%
Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлтүүд:					
Нийт гадаад валют <+/-30%	-13.4%	26.2%	15.1%	10.8%	-8.0%
Нэгж гадаад валют <+/-15%	-0.9%	13.2%	12.0%	8.0%	-1.0%
Том зээлдэгчийн харьцаа <20%	16.5%	18.7%	16.1%	14.7%	12.4%
Холбоотой этгээдийн харьцаа <5%	4.8%	4.6%	1.1%	3.9%	4.0%
Холбоотой этгээдийн харьцаа - Нийт <20%	17.1%	16.3%	2.8%	8.7%	13.2%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа >25%	32.6%	40.2%	41.3%	36.3%	38.3%

* Монголбанкны тайлангаар

Бизнесийн ТОЙМ



Бизнесийн тойм

Харилцагчдын
эх үүсвэр

8.0

их наяд төгрөг

Монгол Улсын бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжигч Голомт банк тогтвортой хөгжлийн чиг баримжаатай бизнесийн үйл ажиллагаагаа явуулахдаа жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх олон төсөл хөтөлбөр, арга хэмжээ, сургалтуудыг амжилттай зохион байгуулж, харилцагчдынхаа чадавхыг бэхжүүлэхэд банкны бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй хүргэсээр байна.

Байгууллагын банк

Байгууллагын зээлийн зах зээлд
эзлэх хувь (+SME)

19%

Байгууллагын эх үүсвэрийн
зах зээлд эзлэх хувь (+SME)

25%

Корпорейт харилцагчдыг
дигиталжуулалт

Интернет банк

90%

Монгол Улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч болох уул уурхай, барилга, бүтээн байгуулалт, боловсрол, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ зэрэг бүхий л салбарт харилцагч тус бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тусгайлсан үйлчилгээг хүргэж, санхүүжилт олгон эх орны хөгжлийн голомт байх эрхэм зорилгоо хариуцлагатай биелүүлэн ажиллалаа.

Онцлох санхүүжилт

- Эрчим хүчний хэмнэлт бүхий барилгын төсөлд 42 тэрбум төгрөгийн ногоон хөрөнгө оруулалтын зээлийг олгов.
- Супермаркет, худалдааны төвийн барилга, бүтээн байгуулалтын ажилд зориулан 100 тэрбум төгрөгийн зээл олгож, 620 ажлын байр бий болголоо.
- “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл” хөтөлбөрийн хүрээнд 16 байгууллагад 64.3 тэрбум төгрөгийн зээл олгов.
- Хариуцлагатай уул уурхайн компаниудад 148 тэрбум төгрөгийн зээл олгов.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

- Байгууллагын банк нь харилцагчдынхаа төлбөр тооцоог дигиталчлах зорилгоор олон дигитал бүтээгдэхүүнүүдийг санал болгодог бөгөөд ажилтнуудын цалин (payroll), төлбөр тооцоо хийх (paybill), нэхэмжлэх үүсгэх (billing), орлого, зарлага (Corporate Gateway)-ын гүйлгээгээ хийх процессыг автоматжуулсан бүтээгдэхүүнүүдийг түлхүү санал болгов.
- “Байгууллагын интернет банкны шинэ боломжууд болон мэдээллийн аюулгүй байдлын сургалт”-ын хөтөлбөрийг боловсруулж, Голомт банкны Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэстэй хамтран 30 орчим групп компанийн санхүү, мэдээллийн технологийн 290 гаруй ажилтанд зориулан 40 цагийн сургалт явууллаа. Сургалтын хүрээнд стратегийн ач холбогдол бүхий харилцагч байгууллагуудаа фишинг халдлагын эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дэмжлэг үзүүлсэн үр дүнтэй хөтөлбөр байлаа. Мөн Corporate Gateway, Payroll үйлчилгээнүүдийг санал болгож, 30 байгууллагад борлуулав.
- Уул уурхай, худалдаа үйлчилгээний томоохон 3 компанийн 8000 гаруй ажилтанд зориулсан Ко-бренд картуудыг зах зээлд нэвтрүүлэв.

Санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр

Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар

- Шинээр байгуулж буй супермаркет, худалдааны төвийн барилгын ажилд 100 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Шинэ салбарууд ашиглалтад орсноор 620 ажлын байр бий болж, 80 гаруй үйлчилгээ, 40 мянга гаруй бараа, бүтээгдэхүүнийг хэрэглэгч, үйлчлүүлэгчдэд хүргэх боломжийг бий болгожээ.
- “Magic Store” худалдааны автомат машин буюу худалдагчгүй дэлгүүрийг Монгол Улсад шинээр нэвтрүүлэхэд санхүүжилт олгож, үйлчилгээний төлбөр тооцооны чиглэлээр хамтран ажиллаж байна.
- Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж буй “Хүнсний болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 16 байгууллагад 64.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон байна. Ингэснээр дотоодын үйлдвэрлэл нэмэгдэж, импортын өндөгний хэмжээг 13 хувиар, чихрийн хэмжээг 6 хувиар орлох боломж бүрдлээ. Мөн импортын бүтээгдэхүүнийг орлох зорилгоор дотоодод молоко, шоколад, хүүхдийн шингэн сок болон сүү сүүн бүтээгдэхүүнүүдийг шинээр үйлдвэрлэх, бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулах эдийн засгийн болон нийгмийн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэв.
- Архангай аймгийн нийтийн тээврийн төв чиглэлд үйлчилгээ үзүүлэх 100 хувь цахилгаан автобусны худалдан авалтыг “Back to back LC” буюу аккредитиваар санхүүжүүллээ.

Боловсролын салбар

- ШУТИС-ийн 1-р дамжааны нийт 4500 оюутанд зориулж, 4 төрлийн үйлчилгээг нэг дор багтаасан “All In One” картыг зах зээлд амжилттай нэвтрүүллээ.
- ШУТИС-ийн Төв номын сангийн 3 давхрын 457.7 м.кв талбайг тохижуулан оюутан, залуусыг тав тухтай орчинд хичээллэх боломжоор хангаж, тухайн танхимыг Голомт банкны нэрэмжит болгон ашиглалтад оруулав.

Уул уурхайн салбар

Тогтвортой, ногоон санхүүжилт

- Эрчим хүчний хэмнэлттэй бараа, ажил үйлчилгээ үзүүлдэг корпорейт харилцагчаас бүтээгдэхүүн үйлчилгээ авч буй хэрэглэгчдэд зориулж хөнгөлөлттэй нөхцөл бүхий ногоон бизнесийн болон хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэв.
- Нийлүүлэлтийн гинжин хэлхээг санхүүжүүлэх ажлын хүрээнд “Сүлжээ дэлгүүрийн авлага барьцаалсан зээл”-ийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлсэн. 300 гаруй жижиг, дунд аж ахуйн нэгж, сүлжээ дэлгүүрт авлагаа барьцаалж, эргэлтийн хөрөнгөө санхүүжүүлэх боломж бий болжээ.
- “Монгол Улсын ногоон таксономи”-ийн дагуу ногоон зээлд ангилагдсан эрчим хүчний хэмнэлт бүхий барилгын төслүүдэд нийт 42 тэрбум төгрөгийн ногоон хөрөнгө оруулалтын зээл олгожээ.
- Уул уурхайн түүхий эд материалын худалдан авалтад зориулж 7.0 сая ам.доллар буюу 24.1 тэрбум төгрөгтэй тэнцэх SWAP хэлцэл хийж, харилцагчдыг ханшийн эрсдэлээс хамгаалжээ.



500+

компани

Арга хэмжээ

Financial Managers' Convention

Жил болгон уламжлал болгон зохион байгуулдаг “Financial Managers’ Convention” арга хэмжээг “Think Globally, Act Locally” уриан дор 5 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээний гол зорилго нь тухайн жилийн эдийн засаг, санхүүгийн үр дүн, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг дүгнэж, ирж буй жилүүдийн эдийн засгийн төлөв байдлын талаар хэлэлцэж, оролцогчид туршлагаа хуваалцдаг. 2023 оны тухайд арга хэмжээний онцлох хөтөлбөр болох панель хэлэлцүүлгийг “Тогтвортой санхүүжилт” сэдвээр явуулж, жил ирэх бүр бизнесийн салбарт хүчтэй нөлөөлөх болсон тогтвортой санхүүжилтийн талаарх ойлголтыг хамтдаа хэлэлцэв. Мөн энэ үеэр Голомт банкны эдийн засгийн мэргэжилтнүүдийн илтгэл, дүгнэлтүүд болон олон улс дахь эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг хүргэлээ.



АЛТНЫ | 20 ФОРУМ | 23

350+

компани

Алтны Форум

Монгол Улсын эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болсон уул уурхайн салбарын хөгжлийг түүчээлэгч бизнесүүдийг дэмжих зорилготой “Алтны Форум” арга хэмжээг 2023 онд 4 дэх удаагаа амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Монгол Улсын алт олборлогч топ аж ахуй нэгжээс гадна уул уурхайн машин механизм, тоног төхөөрөмж үйлдвэрлэгч, нийлүүлэгч байгууллагуудын 350 гаруй төлөөлөл оролцож, уул уурхайн салбар, тэр дундаа алтны зах зээлийн орчинд гарсан өөрчлөлт, түүнд нөлөөлсөн хүчин зүйлийн талаар хэлэлцлээ.



ADVENTURE TOUR 2023

30+

компани

Wild adventure tour

Голомт банкны топ харилцагч байгууллагын удирдлагуудын дунд “Wild Adventure Tour – 2023” арга хэмжээг Төв аймгийн Баян-Өнжүүл сумын “Тоомтын агуй”-д зохион байгууллаа.

Жижиг, дунд бизнесийн банк

Татан төвлөрүүлсэн эх
үүсвэрийн хэмжээ

+25%

Жижиг, дунд бизнесийн
зээлийн багц

+27%

Төслийн зээлийн багц

+59%

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэн бизнесээ дараагийн шатанд гаргахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн ажиллалаа.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

ПОС-ын орлого барьцаалсан дижитал зээл

Голомт банк 2023 онд анх удаа нийт ПОС эзэмшигч худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэдээ зориулан хүссэн үедээ, хаанаас ч, нэмэлт барьцаагүй, шуурхай авах боломжтой “ПОС-ын орлого барьцаалсан дижитал зээл”-ийн бүтээгдэхүүнийг амжилттай нэвтрүүллээ. Ингэснээр Голомт банкны энгийн болон EasyPay-ийн ПОС төхөөрөмжөөр борлуулалтын орлогоо хүлээн авдаг харилцагчид Интернэт банк, Смарт банк ашиглан бизнесийн зээлийг хамгийн хялбараар авах боломжтой юм.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын гэрээний орлого барьцаалсан зээл

Голомт банк “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ханган нийлүүлэгчдэд бараа, ажил, үйлчилгээгээ гүйцэтгэхэд нь шаардлагатай санхүүжилтийг тусгай нөхцөлтэй зээлийн бүтээгдэхүүнээр дамжуулан 2023 оноос олгож эхлээд байна. Ингэснээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулсан ба Голомт банкны харилцагч бол гэрээний үнийн дүнгийн 70 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний зээлийг барьцаа хөрөнгийн хөнгөлөлт эдлэн авдаг боллоо.

Сүлжээ дэлгүүрийн ханган нийлүүлэгчдэд зориулсан бизнесийн зээл

Сүлжээ дэлгүүрт бараа, бүтээгдэхүүн нийлүүлдэг бизнес эрхлэгчдэд зориулсан тусгай нөхцөлтэй авлага барьцаалсан зээлийг нэвтрүүллээ. Ингэснээр бизнес эрхлэгчид барааны төлбөр орж ирэх өдрөө хүлээх шаардлагагүйгээр авлагаа барьцаалан зээл авч, санхүүгийн хэрэгцээгээ шийдэх боломжтой болов.

Хүнсний болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зээл

“Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 36 дугаар тогтоолын хүрээнд “Хүнсний болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих зээл”-ийн хөтөлбөрт Голомт банк арилжааны банкнуудаа манлайлан оролцож, нийт санхүүжилтийн 21 хувийг дангаар бүрдүүллээ.

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл

“Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл”-ийн нөхцөл шинэчлэгдлээ. Энэхүү зээлийг 2021 оны 7-р сард Голомт банк анхлан зах зээлд нэвтрүүлж, санхүүжилт олгож байсан бол өдгөө эмэгтэй удирдлагатай аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгч 500 гаруй эмэгтэй бизнесээ өргөжүүлэн үйл ажиллагаагаа дараагийн түвшинд гаргаж чадсан байна.



Төсөл, хөтөлбөр

“Women Owned” тохирлын тэмдэг

Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор МҮХАҮТ-тай хамтран гаргасан “Women Owned” тохирлын тэмдгийг албан ёсоор 2023 онд олон нийтэд танилцуулж, заах зээлд хэрэглээнд нэвтрүүлээ. Ингэснээр Голомт банк энэ төрлийн тохирлын тэмдгийг Монгол Улсад гаргаж буй анхны байгууллага болсон юм. “Women Owned” тохирлын тэмдгийг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ байршуулснаар тухайн бизнесийн үйл ажиллагааг эмэгтэй хүн эрхлэн явуулдаг гэдгийг шууд илэрхийлнэ. Мөн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд таниулах, худалдан авалтыг нэмэгдүүлэхээс гадна цаашлаад олон улсын зах зээлд гарахад томоохон дэмжлэг болох юм.



“Менторшип” хөтөлбөр

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлж, бизнесээ дараагийн шатанд гаргахад нь зөвлөн дэмжих зорилгоор Голомт банкнаас хэрэгжүүлдэг “Менторшип” хөтөлбөрийг 2 дахь жилдээ хэрэгжүүллээ. Энэхүү хөтөлбөрт Голомт банк болон Монголын томоохон компаниудын үүсгэн байгуулагч, удирдлагууд ментороор хамтран ажиллан жижиг, дунд бизнесүүдтэй туршлага мэдлэгээ хуваалцаж, зөвлөх үйлчилгээний мэргэжилтнүүд байгууллагын үр дүнгийн стратеги менежментийг сайжруулахад чиглэсэн сургалтуудыг явуулахаас гадна банкны зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлж, хөтөлбөрт хамрагдсан байгууллагуудын үйл ажиллагааг богино хугацаанд, оновчтой хөгжүүлэхэд чиглэсэн олон арга хэмжээг хэрэгжүүллээ.



Сургалт, хөгжил

Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх төсөл

Голомт банк, Азийн сангийн хамтын ажиллагааны хүрээнд Канадын Засгийн газрын санхүүжилтээр “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх” төслийг хэрэгжүүллээ. Төслийн хүрээнд бизнес эрхлэгч 225 эмэгтэйг 12 удаагийн сургалтад хамруулж, 78 бизнес эрхлэгчийг 7 удаагийн нетворкинг арга хэмжээнд оролцууллаа. Мөн 191 бичил бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж, нийслэл болон орон нутгийн бизнес эрхлэгч 53 эмэгтэйд удаагийн “Бизнес инкубатор үйлчилгээ”-г тус тус үзүүллээ.



Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр

“Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн Ментор клуб” ТББ-тай хамтран “Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөр”-ийг зохион байгууллаа. Хөтөлбөрийн хүрээнд нийслэл болон орон нутгийн бизнес эрхлэгч нийт 380 эмэгтэй Санхүүгийн удирдлага, Хямралын үеийн санхүүгийн удирдлага, Онлайн төлбөр тооцоо, Дижитал маркетинг, Харилцааны ур чадвар, Бүтээлч менторшип хөтөлбөр зэрэг нийт 37 төрлийн санхүүгийн болон хувь хүний хөгжлийн 16 удаагийн давтамжтай сургалтад хамрагдлаа.



450+

харилцагч

Арга хэмжээ

Business conference

Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг түүчээлэгч аж ахуйн нэгжүүд, бизнесийн салбарын манлайлагчдад зориулсан “Business conference” арга хэмжээ зохион байгуулагдлаа. Энэ үеэр олон улсын эдийн засгийн төлөв байдал, бизнесийн салбарын чиг хандлагын талаар мэдээлэл солилцон дэлхийн жишгийг Монгол хөрсөнд буулган гадны бизнесүүдийн оновчтой стратегийг эх орондоо хэрэгжүүлэхэд анхаарч, “Think globally, act locally” уриан дор оролцогчид хуран чуулсан юм.



Digital SME

2 0 2 3

Digital SME

Голомт банк бизнес эрхлэгчид, тэр дундаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй хүргэж, үүнд чиглэсэн олон үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг. Энэ хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд технологи, дижиталчлалын хувьсал хийх, дижитал системийн хэрэглээг нэмэгдүүлэх, хөгжүүлэх боломжийг хамтдаа эрэлхийлэх зорилготой “Digital SME-2023” арга хэмжээг Нийслэлийн жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төв болон Нийслэлийн бизнес инновац хөгжлийн газартай хамтран зохион байгуулав. “Digital SME-2023” нь оролцогчдодоо харилцан мэдээлэл, туршлагаа солилцох боломжийг олгож, жижиг, дунд бизнесийн салбарыг хөгжүүлэх оновчтой шийдэл, боломжийг хамтдаа эрэлхийлсэн үр дүнтэй үйл ажиллагаа болсон юм.

Иргэдийн банк

Цалингийн зээлийн багц

↑ 27%

Ахуйн хэрэглээний зээлийн багц

↑ 81%

Дижитал цалингийн зээлийн багц

↑ 111%

Өөрийн эх үүсвэрийн орон
сууцны зээл

↑ 43%

Автомашин зээл

↑ 45%

Гадаад төлбөр тооцоо

↑ 15%

Даатгалын хураамжийн орлого

↑ 26%

Голомт банк харилцагч төвтэй банкны үйлчилгээ буюу хадгаламж, харилцах, дижитал банк, зээл, картын бүтээгдэхүүн, гадаад төлбөр тооцоо, даатгал зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг Монгол Улсын өнцөг булан бүрд суугаа нэг сая гаруй харилцагчдаа салбар тооцооны төвүүд болон цахим сувгуудаараа хүргэн ажиллаж байна.

2023 онд харилцагчдын богино хугацааны санхүүгийн хэрэгцээг хангах зориулалт бүхий ахуйн хэрэглээний зээлийг салбар болон дижитал сувгаар олгож ажиллалаа. Иргэдээс татсан эх үүсвэр 15.2%-аар өсөж, 3,512 тэрбум төгрөгт, орон сууцны зээл 21.5%-аар өсөж, 1,037 тэрбум төгрөгт, хэрэглээний зээл 35.1%-аар өсөж, 1,199 тэрбум төгрөгт тус тус хүрэв.

Цалингийн харилцагч байгууллага болон ажилтнуудад цалингийн зээлийн таатай нөхцөл санал болгон цалингийн зээлийн багцын өсөлтийг нэмэгдүүлэв. 10.2 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлогыг бүрдүүлж, салбарын өсөлтөөс давсан өсөлтийг үзүүлэв. Даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэн ач холбогдлыг таниулан сурталчилж, зээлдэгч нарын 90-ээс дээш хувийг даатгалд хамрууллаа.

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

- Нийт харилцагчдаа зориулан богино хугацаанд уян хатан нөхцөлтэйгөөр санхүүгийн хэрэгцээгээ хангах боломж бүхий дижитал цалингийн зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүлээ.
- Албан ёсны борлуулагч, харилцагч байгууллагынхаа автомашины зээлийн борлуулалтаар дэмжин ажиллав.
- Онлайн дэлгүүрүүдээс бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хурдан, хялбар, таатай нөхцөлөөр зээлээр авах боломжийг бүрдүүлээ.
- Онлайн дэлгүүрүүдээс ногоон ангилалд багтах шалгуурын дагуу бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хурдан, хялбар, таатай нөхцөлөөр зээлээр авах боломжтой боллоо.
- Төлбөрийн мэдээллийг илгээхээс өмнө хүлээн авагчийн статусыг таньж, алдаатай гүйлгээ илгээх, хугацаа алдахаас урьдчилан сэргийлэх зориулалттай шинэлэг шийдэл бүхий pre-validation үйлчилгээг шинээр нэвтрүүлэв.
- Голомт банк нь байгууллагын харилцагчдаа зориулан гадаад шилжүүлгийн цоо шинэ суваг болох VISAB2B Connect үйлчилгээг VISA компанитай хамтран төлбөр тооцооны үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж, 108 улс руу шилжүүлэг хийх боломжтой боллоо.



Төсөл, хөтөлбөр

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан”-г банк хоорондын төлбөр тооцооны үйл ажиллагаагаар дэмжин 868 сая төгрөгийг санд төвлөрүүлж ажилласан байна.



“Алтантүлхүүр” хүүхдийн сан

Төрлөхийн зүрхний гажигтай хүүхдүүдийг эх орондоо оношлон, мэс засал хийж, амь насыг нь аврах зорилготой уг төслийг Голомт банк эхэлсэн цагаас нь дэмжиж, санхүүгийн болон шаардлагатай бусад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж буй билээ. Цаашид нийгмийн хариуцлагын хүрээнд “One Sky” хүүхдийн төлөөх ОУ-ын байгууллагатай хамтран хүүхэд хөгжлийн тоглоомын төвийг байгуулах ажилд дэмжлэг үзүүлэн ажиллахаар боллоо.



МИК

Ипотекийн зээлийг нэн тэргүүнд зорилтот харилцагчид нь хүргэх, нээлттэй шударга тогтолцоог бүрдүүлэх зорилгоор зохицуулагч байгууллагуудтай хамтран удирдлагаар хангаж, 205 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр 1980 иргэнд орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй зээл олголоо.

Аян, урамшуулал, борлуулалт



“BIG Loyalty” урамшуулалт хөтөлбөр

Голомт банкны нийт харилцагчийг идэвхжүүлэх, үнэ цэнтэй, тууштай харилцагчдыг нэмэгдүүлэх “BIG Loyalty” урамшуулалт хөтөлбөрийг 6 сарын турш хэрэгжүүллээ. Хөтөлбөрт 930,000 харилцагч хамрагдаж, лоялти оноо болон бусад урамшуулалд идэвхтэй хамрагдлаа.



“GenZ Loyalty” урамшуулалт хөтөлбөр

Шинэ үеийн хүүхэд залуусыг Голомт банкны ирээдүйн үр ашигтай харилцагч болгох, банкны үйлчилгээг шинэлэг байдлаар хүргэж таниулах “GenZ Loyalty” урамшуулалт хөтөлбөрийг 2 дахь жилдээ амжилттай хэрэгжүүллээ. Энэхүү аянд 7-25 насны 69,000 харилцагч хамрагдлаа.



“New born” аян

Нийслэлийн болон орон нутгийн нийт 19 амаржих газартай хамтран ажиллаж, шинээр мэндэлж буй бяцхан үрсийг Голомт банкны харилцагчаа болгох “New born” аяныг 2 дахь жилдээ хэрэгжүүллээ. Аяны үр дүнд 3000 гаруй ээжид гарын бэлэг өгч, 1300 шинэ харилцагчийн 1700 бүтээгдэхүүний борлуулалт хийлээ.

Харилцагчийн хувийн хэргийг шинэчлэх аян

Харилцагчаа таньж мэдээгүйн улмаас гарах эрсдэлээс сэргийлэх, харилцагчийн эрсдэлийн үнэлгээ болон сэжигтэй гүйлгээний хяналтыг сайжруулах, байгууллагын эцсийн өмчлөгчийг тодорхойлох зорилготой иргэн болон байгууллага харилцагчийн “Хувийн хэргийг шинэчлэх аян”-г амжилттай хэрэгжүүлж байна.

Шууд борлуулалт

Банкны үйлчилгээг харилцагчийн байгаа газарт нь очиж хүргэдэг Шууд борлуулалтын алба нь 2023 онд 248 байгууллагад ажиллаж, банкны 36,000 орчим бүтээгдэхүүн үйлчилгээг борлууллаа. Шууд борлуулалтын хүрээнд нийт 9.5 тэрбум төгрөгийн зээлийн багцыг бүрдүүлж ажиллав.



Утсан борлуулалт

Харилцагчдад банкны бүтээгдэхүүн үйлчилгээний мэдээллийг түргэн шуурхай хүргэх, халамжлах, зайнаас борлуулалт хийх Утсан борлуулалтын алба нь 2023 онд нийт 320,000 харилцагч руу амжилттай холбогдон борлуулалт хийж, мэдээлэл хүргэсэн бөгөөд 51,000 ширхэг бүтээгдэхүүн борлууллаа.

Харилцагчийн үйлчилгээний төв

Харилцагчийн дуу хоолой, санал гомдлыг “Call center”, IVR болон онлайн шугамаар дамжуулан нийт 1.2 сая удаагийн хандалтыг 99.3 хувийн гүйцэтгэлтэйгээр цаг алдалгүй хүлээн авч, мэдээлэл зөвлөгөө өглөө. Нийт дуудлагын 95 хувийг харилцагчдын анхны хандалтаар хүлээн авсан байна. Мөн харилцагч салбарт хандан авдаг байсан 10 үйлчилгээг “Call center”-ийн зайны үйлчилгээнд шилжүүлж, харилцагчдын цаг хугацааг хэмнэлээ.

Дижитал банк

Дижитал сувгийн нийт хэрэглэгчийн тоо

↑ **16.4%**

Дижитал сувгийн идэвхтэй хэрэглэгчийн тоо

↑ **17.1%**

Дижитал сувгийн нийт гүйлгээний тоо

↑ **38.6%**

SocialPay нийт хэрэглэгчийн тоо

↑ **37.2%**

SocialPay идэвхтэй хэрэглэгчийн тоо

↑ **24.1%**

Дижитал сувгийн SocialPay гүйлгээний тоо

↑ **121.4%**

Corporate Gateway үйлчилгээний хэрэглэгчийн тоо

↑ **32.6%**

Голомт банк Монгол Улсын банкны салбарт технологийн дэвшил, хиймэл оюун ухаанд суурилсан алгоритмын шинэчлэл хөгжүүлэлтийг тогтмол хийж, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний автоматжуулалт, хэрэглээний хялбар шийдлийг бий болгон, инновац шингэсэн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн сайжруулалт, хөгжүүлэлтүүдийг хийж ажиллалаа.

2023 онд банк өөрийн нийт дижитал сувагтаа 320 орчим хөгжүүлэлтийг хийснээс 85 хувь нь шинэ сайжруулалт, үйлчилгээний боломжийг тэлэхэд чиглэсэн бол 15 хувь орчим нь харилцагчийн туршлагад үндэслэсэн “Алдаагүй дижитал банк” зорилтын хүрээнд хийгдсэн сайжруулалтын ажлууд байв.

Банкны дижитал шилжилтийн стратегийн үр дүнд нийт идэвхтэй харилцагчдын 73 хувь нь дижитал банкны идэвхтэй хэрэглэгч боллоо.



Кредит картын зах зээлийн

48%

Нийт дебит картын тоо

735,000

Харилцагч байгууллагуудтай
хамтарсан ко-бренд карт

25

Бүтээгдэхүүн, үйлчилгээ

SocialPay виртуал кредит карт

Монгол Улсын банк санхүүгийн салбарт хамгийн анхны виртуал кредит картыг SocialPay дижитал хэтэвчиндээ нэвтрүүллээ.



Харилцагч байгууллагуудтай хамтарсан ко-бренд картууд

Голомт банк гар утаснаас бүх төрлийн картын төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой дебит, кредит виртуал картыг гуравдагч байгууллагын аппликэйшндээр амжилттай нэвтрүүллээ.

CU виртуал кредит ко-бренд карт



All In One ко-бренд карт





SocialPay 3.0

Монголын анхны хэвтэвч SocialPay аппликейшнаа банк 2023 онд шинэчлэн шинэ өнгө дизайн дэлхийн чиг хандлагын олон шийдлийг агуулсан 3.0 хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Ингэснээр бүх банкны данс руу шилжүүлэг хийхээс гадна QPAY-ын бүх төрлийн QR кодыг SocialPay-ээр уншуулан төлбөр тооцоо хийх боломжтой болсноор Монголын хамгийн олон дэлгүүрт ашиглагдах боломжтой дижитал хэтэвч болов. Мөн БНХАУ-д Virtual UnionPay картын QR кодоо ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой болсон юм.



SocialPay Junior

Хүүхэд залууст зориулсан SocialPay Junior аппликейшныг залуусын хэрэгцээнд нийцүүлэн зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Хүүхэд залуус өөрсдийн сонирхолд нийцүүлэн өнгө төрхийг нь өөрчлөн удирдах, виртуал карт захиалах, биет картаа холбон төлбөр тооцоо зайнаас хийх, мөнгө нэхэмжлэх, шилжүүлэх болон өөрийн дансыг удирдах зэргээр санхүүгийн хэрэгцээг бүрэн хангаж нэвтрүүлэв.

Дижитал сувгийн бусад онцлох бүтээгдэхүүн, үйлчилгээ

- 2023 онд дижитал зээлийн төслийг хэрэгжүүлэн дижитал сувгуудаар цалин, хэрэглээний зээл, ПОС барьцаалсан зээл, тэтгэврийн зээлийг дижитал сувгуудаар хурдан шуурхай авах боломжийг бүрдүүллээ. Ингэснээр цалин, хэрэглээний зээлийн 25% нь дижитал руу шилжсэн байна.
- 2023 оны 4-р сард Төрийн банктай, 2023 оны 9-р сард Капитрон банктай хамтран ажиллах гэрээ байгуулж, банкуудын картууд харилцан АТМ төхөөрөмжүүд дээр гүйлгээ хийх үед шимтгэлийг 100 төгрөг болгон буурууллаа.
- УБЕГ-ын өөртөө үйлчлэх төхөөрөмжүүдэд төлбөр төлөх шийдлийг холбож, нэвтрүүлэв.
- Байгууллага интернэт банкаараа багц гүйлгээ, Visa B2B зэрэг гүйлгээг хийх боломжтой болов.



Ухаалаг Киоск

Банкны карт, дансны үйлчилгээ болон Төрийн үйлчилгээг багтаасан “Ухаалаг Киоск” төхөөрөмжийг 2023 оны 8-р сард зах зээлд нэвтрүүлэв.

Уг киоск нь 20 гаруй төрлийн санхүүгийн үйлчилгээг агуулдаг. Үүнд:

- Бүх төрлийн бэлэн бус гүйлгээ хийх боломжтой. Үүнд, өөрийн данс хооронд, Голомтын данс хооронд, банк хооронд болон гадаад шилжүүлгийн гүйлгээ
- Харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл, хуулга харах, данс нээх, хаах зэрэг дансны бүх төрлийн үйлчилгээ
- Карт захиалах, хаах, төлөв солих зэрэг картын бүх төрлийн үйлчилгээ
- Дижитал хэрэглээний зээл болон тэтгэврийн зээлийн үйлчилгээ
- Санхүүгийн үйлчилгээнээс гадна төрийн үйлчилгээ



Soft POS

Монгол Улсад анх удаа гар утсаа ашиглан ПОС төхөөрөмжийн үйлчилгээ үзүүлэх шийдлийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд Soft Pos үйлчилгээг ашигласнаар аливаа нэмэлт төхөөрөмжийн шаардлагагүйгээр төлбөр тооцооны асуудлаа хялбараар шийдэх боломжтой болсон. Энэ нь NFC буюу зайнаас унших технологид суурилсан, андройд үйлдлийн системтэй бүх төрлийн гар утсанд нийцнэ.



Төлбөр тооцоо

Голомт банкны ПОС төхөөрөмж нь Alipay, Wechat болон Union Pay -ийн хэтэвчээр төлбөр тооцоо хийх шийдлийг нэвтрүүлснээр бизнес эрхлэгчид олон улсад нийтлэг ашиглагддаг дижитал хэтэвчийг төлбөр тооцоондоо хүлээн авч, худалдаа, үйлчилгээгээ шуурхай үзүүлэх боломж бүрдэж байна. Ингэснээр Голомт банк төлбөр тооцооны шийдлээ нэмэгдүүлж, Монгол Улсын банкны салбарт мерчантын үйлчилгээгээр тэргүүлэгч болохоо бататгалаа.

Картыг токенжуулж, илүү хялбар, аюулгүй төлбөр тооцоо хийх боломжтой tokenization шийдлийг Монголбанкттай хамтран зах зээлд анхлан нэвтрүүлсэн.



Валют арилжааны платформ

Интернэт банкны үйлчилгээнд “Арилжааны платформ” цэс нэмж, хэлцэлтэй гүйлгээ хийх боломжийг нэвтрүүлэв. Валют арилжааны платформоор дамжуулан банкны зорилтот харилцагчийн хэрэгцээг арилжааны “сайн” ханшаар түргэн хугацаанд гүйцэтгэх, зорилтот харилцагчтай арилжааны хэлцлийг хялбараар хийх, ханшийн өөрчлөлтийн мэдээллийг харилцагчид хүргэх, зах зээлийн мэдээ мэдээллийг тухай бүр хүргэх боломжтой боллоо.



SWIFT стандартын хэрэгжүүлэлт

Дэлхийн 200 гаруй улсын 11000 гаруй банк санхүүгийн байгууллага нэгдсэн өдөрт дунджаар 4.5 сая цахим зурвас солилцдог олон улсын банк хоорондын төлбөр тооцооны SWIFT системийн 2023 оны байдлаарх стандарт шаардлагуудыг бүрэн ханган ажиллалаа.

Тоон гарын үсэг

Байгууллагад зориулсан тоон гарын үсгийг Corporate Gateway үйлчилгээнд, иргэний интернэт банканд тоон гарын үсэг ашиглан үйлчилгээгээ баталгаажуулах боломжийг нэвтрүүлэв. Ингэснээр цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хоорондоо цахим хэлбэрээр гэрээ хэлцэл хийх, харилцагчтай холбоотой тодорхойлолт мэдээллийг баталгаажуулах, эрсдэл луйвраас сэргийлэх олон боломжууд нээгдэж, цаг хугацаа, зардлаа хэмнэдэг боллоо.



Арга хэмжээ

Нээлттэй ирээдүй – Дижитал аймаг

Голомт банк дижитал шилжилт, дижитал хэрэглээг орон нутагт таниулах зорилгоор “Нээлттэй ирээдүй” технологийн нэгдсэн арга хэмжээг Дархан, Дорнод, Ховд, Баянхонгор аймгуудад амжилттай зохион байгууллаа. Энэ хугацаанд арга хэмжээгээр дамжуулан нийт 4000 орчим иргэн, харилцагчид хурдацтай хөгжиж буй техник технологийн шинэ шийдлүүд болон сүүлийн үеийн дижитал бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулж, мэдээлэл хүргэсэн байна.



ICT Expo 2023

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хамгийн том нэгдсэн арга хэмжээ “ICT Expo 2023”-д Голомт банк SocialPay 3.0 аппликейшн, “Soft POS”, Киоск CRM, Метаверс салбар зэрэг шинэ бүтээгдэхүүнүүдээ танилцуулан гуравдагч байгууллагатай хамтран олон төрлийн хөнгөлөлт, урамшуулаар харилцагчдадаа бэлэг барьсан юм. Энэхүү арга хэмжээнээс Голомт банкны дижитал үйлчилгээ, шинэ шийдлүүдийг онцолж, “ICT Expo” арга хэмжээний “Шилдэг бүтээгдэхүүн, үйлчилгээ”-ээр шалгарууллаа.



Пи Эм Ай Монголиа Чаптэр

“Пи Эм Ай Монголиа Чаптэр”-аас зохион байгуулсан “Шинэ үеийн хурдасгуур: Ирээдүйн төслийн удирдагч нарыг хүчирхэгжүүлэх нь” олон улсын бага хурлаас SocialPay 3.0 хувилбарын төслийн удирдлагын туршлага, арга аргачлалыг үнэлэн 2023 оны “Шилдэг төсөл”-өөр онцолж, өргөмжиллөө. Бага хурлыг зохион байгуулагчдын зүгээс Голомт банкны SocialPay 3.0 нь дэлхий даяар төсөлд суурилсан эдийн засагт шилжиж буй энэ үед хиймэл оюун ухаан, дэвшилтэт технологиор дамжуулан хэрэглэгчдийнхээ өдөр тутмын амьдралын хэв маяг болон ажил хөдөлмөрийг хөнгөвчилж, илүү хүчирхэг ирээдүйг бүтээхэд дэмжлэг болохуйц үр дүнтэй төсөл болж чадсаныг сайшаасан юм.



Singapore fintech festival

SocialPay аппликейшн Азийн хамгийн том финтекийн арга хэмжээ “Singapore Fintech Festival 2023”-д амжилттай оролцлоо. Уг арга хэмжээнд нийт 134 орны 62,000 гаруй байгууллага уригдан санхүүгийн салбарт нэвтрүүлсэн технологийн шилдэг шийдлүүдээ танилцуулсан байна. “Singapore Fintech Festival”-д Монгол Улсыг төлөөлөн анх удаа Голомт банкны SocialPay аппликейшн болон “QPay Mongolia, Mongol iD” үйлчилгээ хамтран оролцож, олон улсын банк, санхүүгийн салбарын төлөөллүүдэд өөрийн үйлчилгээг танилцуулахын зэрэгцээ харилцан туршлага солилцлоо.

Дэд бүтэц, технологийн шинэчлэл

Банкны дата төвийн шинэчлэл

2023 онд банкны хэмжээнд ашиглагддаг 3 дата төвийг шинэчилж, олон улсын стандартад нийцсэн цахилгааны болон хөргөлтийн төхөөрөмжүүдийг суурилуулсан нь сервер, тоног төхөөрөмжийн ашигтай ажиллагааг нэмэгдүүлэх, зардал бууруулах оновчтой шийдэл болсон.

Шинэчлэл, сайжруулалтын бусад ажил

- COBIT 5 фреймворкын 20 орчим процессыг олон улсын стандартын дагуу хэрэгжүүлж байна.
- Голомт банк 2021 оноос эхлэн үйл ажиллагааны хурдыг нэмэх, ажилтны гар ажиллагааг бууруулах зорилгоор роботик процесс автоматжуулалтыг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2023 оны байдлаар банкны төлбөр тооцооны нэгжид тайлан гаргах, файл бэлтгэх, зөөх, и-мэйл илгээх, системд гүйлгээ, тохиргоо хийх гэх мэт нийт 43 үйл явцыг роботоор автоматжуулан жилд 16,000 гаруй хүн цагийг хэмнэж байна.
- Банкны хэмжээнд ашиглагддаг бүх төрлийн сүлжээ /интернэтийн сүлжээ, салбар тооцооны төвүүдийн сүлжээ, оффисын сүлжээ болон олон улсын картын сүлжээ/-г өргөтгөж, актив-актив ажиллагаа бүхий давхар нөөц холболтуудтай болсон.
- Kubernetes containerized шийдлийг амжилттай нэвтрүүлснээр microservices, cloud, auto scaling, automating deployment ажиллагаа хийгддэг боллоо.
- ProActive хяналтын шийдэл болох Application Performance Monitoring шийдлийг нэвтрүүллээ.
- Программ хангамж хөгжүүлэлтийн процесст GitOps шийдлийг амжилттай нэвтрүүлэв.

Олон улсын бизнес, хамтын ажиллагаа

Голомт банк Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагууд болох Moody's болон S&P Global байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийг 2011 оноос хойш үнэлүүлж, хамтран ажиллаж байна. 2023 онд тус агентлагууд Голомт банкны зээлжих зэрэглэлийг хэвээр үлдээж, баталгаажууллаа. Голомт банкны зээлжих зэрэглэлийн үнэлгээ Монгол Улсын Засгийн Газрын зээлжих зэрэглэлийн үнэлгээтэй ижил түвшинд байна.

Олон улсын зээлжих зэрэглэл

Moody's

Ангилал	"Moody's" үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B3
Төлөв	Stable
Эрсдэлийн үнэлгээ – Гадаад валют	B3/NP
Эрсдэлийн үнэлгээ – Дотоод валют	B2/NP
Зээлжих чадварын суурь үнэлгээ	B3

S&P Global

Ангилал	"S&P" үнэлгээ
Зээлжих зэрэглэлийн үнэлгээ	B/Stable/B
Төлөв	Stable
Үнэт цаасны үнэлгээ	B
Хөврөх чадварын үнэлгээ	B+



Moody's

Урт хугацаат гадаад
валютаар хүлээсэн
үүргийг биелүүлэх зэрэглэл

B3/Тогтвортой

S&P Global

Урт хугацаат гадаад
валютаар хүлээсэн үүргийг
биелүүлэх зэрэглэл

B/Тогтвортой

Олон улсын санхүүгийн
байгууллагаас татсан
санхүүжилтийн хэмжээ

+\$127.7 сая

Голомт банк ногоон, тогтвортой хөгжлийн чиг баримжаатай бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн тэгш хүртээмж, бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, дотоодын жижиг, дунд бизнесийг дэмжих зорилтот санхүүжилтийг нөлөөллийн хөрөнгө оруулалтын сангуудаас татсан. Эдгээр санхүүжилт нь урт хугацаатай, хөнгөлөлттэй нөхцөлтэй байхаас гадна мэргэшсэн зөвлөх баг банк болон харилцагчдын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Швейцар улсад төвтэй responsAbility Investments AG нь байгаль орчинд ээлтэй, бичил болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжихэд зориулан урт хугацаат санхүүжилтийг олгов.

ОУСК-ийн Гадаад худалдааны санхүүжилтийн хөтөлбөрт хамтрагч банкаар элсэв. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Голомт банк Дэлхийн 230 гаруй арилжааны банкуудтай импортын аккредитив, төлбөрийн баталгаа, факторинг, импортын зээлийн чиглэлээр хамтран ажиллаж байна.

Голомт банк тогтвортой хөгжлийг дэмжих, харилцагчдынхаа ногоон зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд WaterEquity байгууллагатай хамтран НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 6-р зорилго болох “Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламж”-д хамаарах төслүүдэд санхүүжилт олгож эхэллээ.



Олон улсын корреспондент банкнууд

Голомт банк Европын тэргүүлэх санхүүгийн байгууллагууд болох Oddo BHF банканд ам.доллар болон еврогийн ностро данс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Crown Agent Bank болон Испанийн Caixa банкуудад банкнуудад евро болон фунт стерлингийн дансуудыг тус тус нээж, корреспондент банкны түншлэлээ амжилттай өргөжүүлэв. Ингэснээр нийт 15 гадаад валютын 50 корреспондент банкны дансаар дамжуулан гадаад төлбөр, тооцооны үйлчилгээг хамгийн өргөн сонголттойгоор гүйцэтгэж байна.

Банк нь харилцагчдынхаа хил дамнасан төлбөр тооцоог хурдан, шуурхай хийж гүйцэтгэх зорилгоор корреспондент банкнуудын хамтын ажиллагаа, сүлжээг тогтмол өргөжүүлэн ажилладаг.




SWIFT сүлжээгээр хийгдэж буй гадаад төлбөр тооцооны зах зээлд эзлэх хувь


Голомт банк 2023 онд Монгол Улсын банкны системийн нийт гадаад төлбөр тооцооны гүйлгээний 32 хувийг дангаар хийж гүйцэтгэсэн тухай SWIFT олон улсын байгууллагын тайланд дурджээ.

Гадаад төлбөр тооцооны зах зээлд эзлэх хувь

Илгээсэн гүйлгээний тоогоор



Илгээсэн гүйлгээний дүнгээр



Эх сурвалж:
Swift Watch report



Олон улсын корреспондент банкнууд

Гадаад худалдааны санхүүжилт

Голомт банк харилцагчдынхаа гадаадын бэлтгэн нийлүүлэгчдээс уул уурхай, үйлдвэрийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, сэлбэг, хүнс болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний худалдан авалтад зориулан олон улсын 100 гаруй банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран гадаад худалдааны санхүүжилтийн цогц үйлчилгээг хүргэн ажиллалаа.


Тухайлбал, 2023 онд Голомт банкны гадаад худалдааны санхүүжилтийн нийт багц 701 тэрбум төгрөг байгаа бол банкны нийт Гадаад худалдааны санхүүжилтийн эргэлт 2.2 их наяд төгрөг буюу энэ хэмжээний бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, болон төслүүдийг худалдааны санхүүжилтийн үйлчилгээгээр дэмжин ажиллав.

Монгол Улс 2023 онд нийт 31.6 их наяд төгрөгийн бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж импортолсон бөгөөд үүний 37.4 хувийг машин, тээврийн хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл болон түүний эд анги эзэлж байна. Үүнээс Голомт банк нийт 1.3 их наяд төгрөгийн импортын бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг санхүүжүүллээ.

Мөн экспортын гол бүтээгдэхүүн болох нүүрс, ноос ноолуурын бараа бүтээгдэхүүний экспортод зориулан гадны банк санхүүгийн байгууллагуудаас нээгдсэн 1.1 их наяд төгрөгийн дүнтэй тэнцэх аккредитив, гадаад баталгааны хүсэлтийг хүлээн авч, түргэн шуурхай шийдвэрлэн ажиллав. Ингэснээр 2023 оны жилийн эцсийн байдлаар гадаадын худалдан авагчдаас Монгол Улсын үйлдвэрлэгчид рүү нээгдсэн нийт экспортын аккредитивийн зах зээлийн 89.9 хувийг Голомт банк дангаар гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна.



Гадаад баталгаа аккредитивийн зах зээлд эзлэх хувь



Эх сурвалж: Swift Watch report

Олон улсын SWIFT байгууллагаас гаргасан тоон мэдээгээр Голомт банк нь гадаад баталгаа, аккредитив нээх үйлчилгээгээр тэргүүлэх байр сууриа хадгалж дотоодын зах зээлийн 68.5%-ийг эзэлж байна.

Монгол Улсын экспорт болон дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг гадаад худалдааны санхүүжилтээр дэмжиж ажиллав.

- Экспортын гол нэрийн бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжихэд Голомт банк чухал үүрэгтэй оролцож, 2023 онд нийт 67 тэрбум төгрөгийн уул уурхайн тоног, төхөөрөмжийн аккредитив, 233 тэрбум төгрөгийн нүүрсний экспортын аккредитивийг тус тус нээв.
- Монгол Улсад хэрэгжиж буй дэд бүтцийн мега болон үйлдвэрийн бүтээн байгуулалтын төсөлд зориулж Голомт банк БНХАУ-ын Bank of China (BoC), Agricultural Bank of China (ABOC), Industrial and Commercial Bank of China (ICBC), Канад улсын Toronto Dominion Bank (TD) нартай хамтран тендер, урьдчилгаа төлбөр, гүйцэтгэл болон чанарын баталгаануудыг нээн ажиллаа.



- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан нийтийн тээврийн 600 автобус нийлүүлэх тендерт зориулж БНХАУ-ын Bank of China банктай хамтран дэлхий нийтийн тээврийн шилдэг компанийн нэрийн өмнөөс тендерийн, гүйцэтгэлийн болон чанарын баталгаануудыг амжилттай нээв. Мөн Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нийтийн тээврийн хэрэглээнд зориулан байгаль орчинд ээлтэй, нэг удаагийн бүрэн цэнэгээр 200 км туулах хүчин чадалтай цахилгаан автобусны худалдан авалтад зориулан бүтцэт санхүүжилтийн шийдлээр дэмжиж ажиллалаа.
- Харилцагчийнхаа барилгын үйлдвэрлэлд зориулан элс угаах үйлдвэрийн болон хаягдал ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж худалдан авах төсөлд дэмжлэг үзүүлж, Итали улсын MPS банктай хамтран анх удаа урт хугацаат аккредитивийг амжилттай нээв.

Тогтвортой хөгжил



Тогтвортой хөгжил

Ногоон зээлийн
багцын үлдэгдэл

183.04

тэрбум төгрөг

Голомт банк нь Тогтвортой санхүүжилтийн бодлогыг 2015 оноос хойш хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 2019 онд уг бодлогыг "Тогтвортой хөгжлийн бодлого" болгон өөрчилснөөр зөвхөн санхүүжилт бус банкны бүх шатны үйл ажиллагааг хамруулан Тогтвортой хөгжлийн зорилгуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тогтвортой хөгжил

Олон улсын аргачлалын дагуу банкны зээлийн багцаас карбон ихээр ялгаруулж буй эдийн засгийн салбаруудын санхүүжүүлсэн ялгарлыг анх удаа хэмжив.

Ус болон эрчим хүчний хэмнэлттэй төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой зээл олгож эхэллээ.

Голомт банк 2023 оны 2-р сард “Partnership for Carbon Accounting Financials” буюу “Нүүрстөрөгчийн нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн түншлэл” олон улсын байгууллагад гишүүнээр элссэн. Энэ хүрээнд Монгол Улсын банк санхүүгийн байгууллагуудаас анхлан олон улсын аргачлалын дагуу банкны зээлийн багцаас карбон ихээр ялгаруулж буй эдийн засгийн салбаруудын санхүүжүүлсэн ялгарлыг хэмжив. Ингэснээр НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Хариуцлагатай банкны зарчмын жилийн тайландаа оруулж, “Эрнст энд Янг” аудитын байгууллагаар аудитлуулж, тайлагналаа.

Хариуцлагатай банкны зарчмын дагуу уур амьсгал болон усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дунд болон урт хугацааны зорилтоо тодорхойлон тайлагнасан. Голомт банк 2030 он гэхэд уур амьсгалд үзүүлэх нөлөөллийг 30 хувиар бууруулах, усны нөөцөд үзүүлэх нөлөөллийг 5 хувиар бууруулах дунд хэмжээний зорилт тавин ажиллаж байна.

2030 онд ↓30%



2050 онд

↓50%

2030 онд ↓5%



2050 онд

↓10%

Сургалт, хөгжил

- Голомт банк дунд болон урт хугацааны зорилтдоо хүрэхийн тулд байгууллагын томоохон харилцагчдад зориулан тогтвортой санхүүжилт, ногоон зээлийн боломж, байгаль орчин, нийгмийн эрсдэл, түүнийг удирдах, сөрөг нөлөөллөө хэрхэн бууруулах талаар ганцаарчилсан сургалт, зөвлөгөө өгч, хамтран ажиллаж байна. 2023 онд дунджаар 15-20 харилцагч байгууллагын 400-500 удирдлага болон ажилтанд ганцаарчилсан сургалт явуулжээ.
- Хүний эрхийн тухай сургалтад 1846 ажилтан, Жендэрийн бодлогын тухай сургалтад 1839 ажилтан цахимаар хамрагдсан бөгөөд цаашид бүх ажилтны заавал хамрагдах сургалт хэлбэрээр бэлтгэн Голомт банкны дотоод сургалтын академийн цахим хуудсанд байршуулав.
- НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Хариуцлагатай банкны зарчмын сургалтын албатай хамтран “Уур амьсгалын эрсдэлийн санхүүгийн байгууллагад үзүүлэх нөлөөллийн тухай” цуврал 5 сургалтад 341 ажилтнаа хамруулав. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисстой хамтарсан танхимын сургалтад 27 ажилтан, ТоС холбоотой хамтарсан Тогтвортой санхүүжилт, Таксономийн тухай сургалтад 39 ажилтан хамрагдлаа.



Арга хэмжээ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл доор Тогтвортой санхүүжилтийн холбооноос зохион байгуулсан “Тогтвортой санхүүжилтийн долоо хоног” олон улсын хурлын хүрээнд “Уур амьсгалын эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг Голомт банк бие даан амжилттай зохион байгууллаа.



Нэгдсэн Үндэстний байгууллагаас зохион байгуулсан “Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган”-ы гол түншээр ажиллаж, үйл ажиллагаагаа танилцууллаа.

Арга хэмжээний үеийн эрчим хүчний хэрэглээний тодорхой хэсэг буюу тайз, дэлгэц, гэрэл, хөгжим, тоног төхөөрөмжийг нарны цахилгаан үүсвэрээр шийдсэнээр цагт 28.3 кг карбон агаар мандалд ялгарахаас сэргийлж чадсан.

Financial Managers' Convention болон Business Conference

Голомт банкнаас жил бүр зохион байгуулдаг Financial Managers' Convention болон Business Conference-ийг 2023 онд ерөнхий агуулга болон зохион байгуулалт талаас нь тогтвортой хөгжилд нийцүүлж, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй элементүүдийг ашигласнаараа онцлогтой.

Нийт арга хэмжээний үеэр 452.8 кг CO₂ /нүүрстөрөгчийн давхар исэл/ агаар мандалд ялгарахаас сэргийлжээ.

CO₂ бууруулах Голомт банкны уриалгыг дэмжин оролцогчид алхаж, дугуй, скүүтэр, автобус болон цахилгаан автомашин сонгон ирснээр бид нийт оролцогчийн хамтаар 51.6 кг CO₂ хэмнэсэн байна.



278 кг буюу нэг модны 11 жилийн турш шингээх карбоныг хамтдаа хэмнэж чадлаа.


Ногоон зээл

Голомт банк Монгол Улсын Ногоон Таксономийн хэрэгжилтийг хангаж, ногоон тогтвортой зээлийн багцыг ангилан бүрдүүлэхээс гадна 2023 онд зах зээлд шинээр ногоон хэрэглээний зээл, хүү хуваах нөхцөлтэй бизнесийн ногоон зээлийг гаргаснаар нийт 6 төрлийн хөнгөлөлттэй, тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна. 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10 хувийг ногоон, тогтвортой зээлийн багцаар бүрдүүлэх зорилт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

	Хүү (сарын)	Дээд хэмжээ	Хугацаа
Тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүн	1.2% - 1.4%	5-10 тэрбум төг.	30-84 сар
Хүү хуваан төлөх нөхцөлтэй бизнесийн ногоон зээл	1.2% - 1.4%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	84 сар
Ногоон АОС зээл	1.25%-1.4%	160-300 сая төг.	120-240 сар
Эко автомашины зээл	1%-1.1%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	30-96 сар
Ногоон хэрэглээний зээл	1.25%	Бүтээгдэхүүний дүнгээс хамаарна	30 сар
Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих	1.2% - 1.4%	100 сая төг.	36 сар

2022 оны 4-р улирлын байдлаар Голомт банкны ногоон зээлийн багц 95.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол 2023 оны 4-р улирлын байдлаар 183.04 тэрбум төгрөгт хүрч, 91 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан. Энэ нь Голомт банкны зээлийн багцын 4 хувийг эзэлж, нийт банкны салбарын ногоон зээлийн багцын 22.9 хувийг бүрдүүлж байна.

Ногоон зээлийн багц /сая.төгрөг/




Эрсдэлийн үнэлгээ

2023 онд байгаль орчин, нийгмийн эрсдэлийн нийт 1177 үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Эдгээрийн 758 нь эрсдэлгүй буюу байгаль орчин, нийгэмд шууд нөлөөгүй салбарын үнэлгээ бөгөөд давхардаагүй тоогоор 564 харилцагчид зээл олгожээ. Нийт үнэлгээний 419 нь эрсдэлтэй буюу бага, дунд, өндөр нөлөөлөлтэй салбарынх байснаас 260 харилцагчид зээл олгосон байна. Үнэлгээний шаардлага 2022 оноос даруй 107.6 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

2023 оны эрсдэлтэй салбарын үнэлгээг сектороор ангилбал барилгын салбар 33.02%, уул уурхай 7.36%, боловсруулах салбар 33.73%, тээвэр ба агуулах 12.59%, бусад салбарууд дараах хувийг тус тус хувийг бүрдүүлжээ.

2023 оны эрсдэлтэй салбарын үнэлгээ

/эдийн засгийн салбараар/





Төсөл, хөтөлбөр

Хариуцлагатай банкны зарчмын хүрээнд тодорхойлсон нүүрсхүчлийн хийг бууруулах, усны хомсдолд үзүүлэх нөлөөллийг багасгах зорилтын хүрээнд эрчим хүчний хэмнэлтийг дэмжих, ус ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, усны менежментийг сайжруулах чиглэлээр олон улсын нөлөөллийн санхүүгийн байгууллагуудтай хамтран ажилладаг. Үүнд, ус хангамж, ус цэвэрлэх үнэ цэнийн сүлжээнд хамрагдах бичил, жижиг, дунд үйлдвэр, үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. Голомт банк усны чиглэлийн зорилт тавьсан нь Хариуцлагатай банкны зарчимд нэгдсэн олон улсын гишүүн 340 гаруй банк, санхүүгийн байгууллагаас анхны банкаар тодорч, НҮБ-ын Байгаль орчны хөгжлийн хөтөлбөрийн зүгээс сайшаал хүртэж, сайн жишээгээр үнэлэгдэж байна.

Голомт банк ус болон эрчим хүчний хэмнэлттэй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилготой олон улсын нөлөөллийн сангуудаас эх үүсвэр татаж, энэ чиглэлийн харилцагчдад зээл олгож эхэлсэн. Ингэхдээ ус, ариун цэврийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч, бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч, борлуулагч болон эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах гэх мэт зориулалтаар зээл олгож байна.




Жендэрийн манлай байгууллага

Голомт банкнаас харилцагчдадаа зориулан гаргасан “Women Owned” тохирлын тэмдэг, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүн болон чадавхжуулах “Менторшип” хөтөлбөр, Жендэрийн тэгш байдлын хороо болон үүгээр дамжуулан хэрэгжүүлж буй дотоод бодлогыг Монголбанк, Санхүүгийн Зохицуулах хороо, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбооноос үнэлэн 2023 оны “Жендэрийн манлай байгууллага”-аар тодрууллаа.



Нийгмийн хариуцлага



Нийгмийн хариуцлага

Тэтгэлэгт
хамрагдсан нийт
оюутан

+1500 ↑

Голомт банк өндөр ашигтай,
өсөлттэй салбарт хөрөнгө
оруулахаас илүүтэйгээр
байгаль орчин, нийгэмд ээлтэй,
нийгмийн харилцаа хандлагад
өөрчлөлт авчрах төслүүдэд
дэмжлэг үзүүлэхийг зорьдог.

Нийгмийн хариуцлага



ӨВ СОЁЛЫН ГОЛОМТ
ТҮҮХ АРХЕОЛОГИЙН ТӨСӨЛ

“Өв соёлын голомт” төсөл

Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэнд, боловсрол, урлаг соёлыг дэмжих чиглэлээр олон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. 2022 оноос Монголын түүх соёлын үл хөдлөх дурсгал, биет өвийн хадгалалт хамгаалалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, соёлын өвийг дэлхийд таниулах археологийн олон төслүүдийг хэрэгжүүлэх, урт хугацаанд дэмжихээр “Өв соёлын голомт” төслийг санаачлан ШУА-ийн Археологийн хүрээлэнтэй хамтран ажиллаж эхэлсэн. Төслийн хүрээнд хувийн хэвшлийн байгууллагуудаас анхлан археологийн салбарт хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Монголын түүх, шашин, соёлыг судлахад чухал нөлөө, томоохон дэмжлэг үзүүлж байгаа юм. 2023 онд төслийн эхний ажлууд болох Түргэний балгас-Туулын “Хар Түнэ Орд” дурсгалт газарт археологийн малтлага, Булган аймгийн Сэлэнгэ сумын нутагт “Ингэт толгойн хүн чулуу”-ны хөшөөний судалгааны ажлуудыг амжилттай гүйцэтгэжээ.



“OneSky” хүүхэд хөгжлийн байгууллага

Эх орны ирээдүй болсон хүүхэд, багачуудынхаа эрүүл мэнд, боловсролд анхаарал хандуулж, хувь нэмрээ оруулахыг эрмэлздэг бөгөөд 2023 оноос хүүхдийн төлөөх сайн үйлсийн ажлуудаа өргөжүүлэн олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өрнүүлж, Улаанбаатар хотын алслагдсан дүүрэгт амьдардаг бага насны хүүхдүүдийн хөгжлийг дэмжихээр “OneSky” байгууллагатай хамтран ажиллаж байна. “Хүүхэд бүрийн төлөө” уриатай “OneSky” байгууллага нь Вьетнам, Хятад, Хонконг зэрэг орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 2018 онд Монголд “Гэр бүлийн төв”-ийг байгуулсан. Тус төвөөр дамжуулан бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих, хүүхдээ ойлгон хүмүүжүүлэх, суралцах боломжуудыг нь нээхэд туслах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, шинжлэх ухаанд суурилан боловсруулсан хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, хэл яриа, сэтгэл хөдлөл, хоол тэжээл, орчны аюулгүй байдлын талаарх “Гэр бүлийг чадавхжуулах” цогц сургалт хөтөлбөрүүдэд хүүхдүүд, гэр бүл, эцэг эхчүүдийг үнэ төлбөргүй хамруулах юм.



Оюутны тэтгэлэгт хөтөлбөр

Боловсролыг дэмжигч Голомт банк 2023 онд 19 дэх жилдээ “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн шилдэг 100 оюутнаа тодрууллаа. Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулиудын оюутнуудын дунд өргөн цар хүрээнд зохион зохион байгуулагддаг уг тэтгэлэгт хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй 650 гаруй оюутан материалаа ирүүлж, 4 үе шаттайгаар өрсөлдсөнөөс 100 оюутан шалгарсан юм.

Голомт банкны нэрэмжит тэтгэлэгт оюутан болсноор тэтгэлгээс гадна мэргэжлийн ур чадвараа хөгжүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамрагдах, нийгэм рүү чиглэсэн ажлууд хийх, “G-Student” клубт гишүүнээр элсэх, банкны судлаач оюутны багт дадлага, цагийн ажил хийх, цаашлаад ажил, мэргэжлийн карьераа Голомт банкнаас эхлүүлэх зэрэг олон боломжийг бий болгодог.

Голомт банк “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 2003 онд анхлан санаачилж, жил бүр уламжлал болгон хэрэгжүүлсээр ирсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд 50 гаруй их, дээд сургуулийн 1700 оюутанд хоёр тэрбум орчим төгрөгийн тэтгэлэг олгоод байна.



“Зүрх мартахгүй” төсөл

Голомт банкны дэргэдэх Алтантүлхүүр хүүхдийн сан “Зүрх мартахгүй” төслийг 2020 оноос хойш дэмжин ажиллаж байна. Төслийн багийнхан 2022 онд Монгол, Киргизстан, Тува гурван улсын олон мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулан, мэс засал хийж амьдрал бэлэглэсэн юм. Голомт банкны зүгээс тус төсөлд жил бүр санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна шаардлагатай бусад зүйлсээр дэмжин ажилладаг бөгөөд хамтын ажиллагааны үр дүнд одоогийн байдлаар нийт 18 мянган хүүхдийг үзлэг, оношилгоонд хамруулж, 600 гаруй хүүхдэд мэс заслыг амжилттай хийгээд байна.

Төслийн багийнхан анх жилд 44 хүүхдэд мэс засал хийх төлөвлөгөөтэй байсан ч хамтын ажиллагааны үр дүнд санхүүгийн болон бусад асуудлууд тодорхой хэмжээнд шийдэгдсэнээр нэг жилд хийх мэс заслын тоог 350-360 болгон нэмэгдүүлээд байна.




Морин хуурын чуулга

Голомт банкны хамт олон үндэсний язгуур урлагийг түгээн дэлгэрүүлэх, дэлхий дахинд сурталчлах зорилгоор эх орны онцгой өв соёлын гол төлөөлөл болох Монгол Улсын Морин хуурын чуулгын албан ёсны түнш, ерөнхий ивээн тэтгэгчээр 13 дахь жилдээ хамтран ажиллаж байна. Энэ хугацаанд Морин хуурын чуулгын зүгээс дотооддоо төдийгүй дэлхийн тайзнаа нэр хүндээ бататгаж, олон мянган хүний талархлыг хүлээсэн, чанартай уран бүтээлүүдийг эрхлэн гаргаснаас “Playing Love” болон “Novel Melody” зэрэг бүтээлүүд нь олон улсад танигдаад байна. Хоёр байгууллагын хамтын ажиллагааны хугацаанд гадаад болон дотооддоо үндэсний урлагийг сурталчлан таниулж, нийт 40 орчим томоохон тоглолт хийгээд байна.

Үйл ажиллагааны удирдлага





Үйл ажиллагааны удирдлага

Нийт зээлийн
хэмжээ

4.9

их наяд төгрөг

Банкны зээлийн шийдвэр гаргалтыг хурдасгах зорилгоор 2023 оноос “Business process management suites” систем буюу зээлийн үйл ажиллагааны бүтэн процессыг автоматжуулах, нэгдсэн өгөгдлийн сантай болох төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Хүний нөөцийн удирдлага

Голомт банк ажилтан төвтэй стратеги, тасралтгүй суралцах, мэргэжлийн өндөр ёс зүйтэй соёлыг бэхжүүлэх зорилгын хүрээнд ажилтны замналыг тасралтгүй сайжруулах, ажилтан бүрд ээлтэй, сурч хөгжих, өөрийгөө сорих боломжоор дүүрэн тогтолцоог бий болгох замаар банкны урт хугацааны, тогтвортой өсөлт хөгжилд хувь нэмрээ оруулан ажиллалаа.





Ажилтан төвтэй хүний нөөцийн бодлого, хөтөлбөр

- Голомт банк ажилтнуудынхаа сэтгэл ханамж, идэвх, оролцооны түвшнийг тогтмол нэмэгдүүлэхээр соёлыг зорилготойгоор удирдах, удирдлагын манлайллыг нэмэгдүүлэх, үе хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааг удирдах олон сургалт, төсөл хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэн ажилласны үр дүнд ажилтны энгэйжмент үзүүлэлт 87 хувьд хүрсэн байна.
- Голомт банк ажилтан төвтэй хүний нөөцийн бодлогын хүрээнд ажилтнуудаа шударгаар үнэлж, гүйцэтгэл, ур чадварт тулгуурлан цалин хөлс, урамшуулал, хөнгөлөлт хангамжийг тогтмол нэмэгдүүлэхийг зорин ажилладаг бөгөөд 2023 онд нийт ажилтны цалинг 30 хүртэл хувиар нэмлээ.
- Ажилтнуудаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, үүний үр дүнд үндэслэн ажилтны биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, санхүүгийн эрүүл мэндийн дархлааг нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.
- Ажилтнуудынхаа ажил, амьдралын тэнцвэрийг хадгалах зорилгоор уян хатан ажлын цаг, зайнаас ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэв. Мөн урлаг, спортын уралдаан, тэмцээнүүд, сонирхогчдын клубүүдийн үйл ажиллагаанд хамруулав.



Ажиллахад хамгийн таатай газар

“Итгэлцэл дээр суурилсан, өндөр гүйцэтгэлтэй байгууллагын соёл”-ыг бий болгох зорилгоор судалгаа хийж, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг тусгай эрх бүхий олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага болох “Great place to work institute”-ээс “Ажиллахад хамгийн таатай газар” батламжийг Голомт банк байгууллагын дотоод соёлоороо тэргүүлэн хоёр дахь жилдээ авлаа. 2022 онд Монгол Улсын банк, санхүүгийн салбараас анхлан авч байсан бол “Ажиллахад хамгийн таатай газар” гэдгээ 2023 онд дахин бататгаж, хоёр жил дараалан батламж авсан анхны байгууллага болсон юм.

Ажилтан болон тэдний гэр бүлийг дэмжих бодлого

- Ажилтны өөрийн болон хүүхдүүдийн төрсөн өдрийн цалинтай чөлөө, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр, жирэмсэн ажилтнуудын ажлын цагийг богиносгох боломжоор ханган ажиллалаа.
- Зуны улиралд ажилтнууддаа цэвэр агаарт гарч, амрах боломжийг “Ойн булаг зуслан” хөтөлбөрөөр дамжуулан олгодог. Уг хөтөлбөрийн хүрээнд тусгайлан тохижуулсан, тохитой зуслангийн байшинд гэр бүлийн хамтаар амрахаас гадна дурсамж бүтээх боломжтой.

Сургалтын цаг

209,600

Оролцогчдын тоо

104,558

1 ажилтанд ногдох сургалтын цаг

96

Дотоод сургагч багшийн тоо

172

Сургалт, хөгжил

- Ажилтан бүр тасралтгүй суралцаж хөгжих, мэдлэгээ хуваалцах соёлыг бэхжүүлэх зорилгоор “Ажилтан та - Хөгжлийн голомт”, “Удирдах ажилтан бүр сургагч багш” уриан дор 2023 оны сургалт хөгжлийн олон шинэлэг үйл ажиллагааг хэрэгжүүллээ.
- Тасралтгүй суралцах соёлын хүрээнд сургалтын олон арга хэлбэрийг ашигладаг бөгөөд 2023 онд micro learning, blended-learning, давтан сургах аргачлалуудыг сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллалаа. Ажилтнуудад өөрийн цагийн хуваарьтаа тохируулан орон зай, цаг хугацаа хамаарахгүйгээр сургалт хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдах боломжийг сургалтын систем болон гар утасны “Golomt academy” аппликейшнээр дамжуулан олгож байна.

Цахим сургалт

Голомт академийн цахим сургалтын платформоор дамжуулан дотоодын сургагч багш нар 150 гаруй цахим сургалт, контентыг бэлтгэлээ. Сургалтад давхардсан тоогоор 82,000 удаагийн хандалтаар ажилтнууд хамрагдсан байна.

Удирдах ажилтны хөгжлийн хөтөлбөр

Банкны залгамж халааг тасралтгүй бэлтгэх, ажилтны удирдах ур чадварыг тогтмол хөгжүүлэх зорилгоор “Удирдах ажилтны хөгжлийн хөтөлбөрүүд”-ийг амжилттай хэрэгжүүллээ. Үүнд:

- Европын CPD сертификаттай зөөлөн ур чадвар хөгжүүлэх “Дэлхийн түвшний менежер 1, 2” сургалт
- Шинэ удирдах ажилтнуудыг ажлын байранд богино хугацаанд дасан зохицоход чиглүүлэх “Менторшип” хөтөлбөр
- Хүний нөөцийн үйл ажиллагааны тухай ерөнхий суурь ойлголт өгөх “Non-HR Manager” хөтөлбөр
- Шинэ удирдах ажилтны залгамж халаа бэлтгэх “Удирдах ажилтан бэлтгэх” хөтөлбөр

Хамтын ажиллагаа

- Голомт банкнаас жижиг, дунд бизнес эрхлэгчдийг үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Менторшип – 2023” хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгч 60 гаруй байгууллагын хүний нөөцийн ажилтнуудыг чадавхжуулж байна.
- Сайн сайхныг санхүүжүүлнэ уриатай Голомт банк нийгмийн хариуцлагын хүрээнд Европын холбооны санхүүжилтээр “Дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх” төслийг Монгол Улсад анх удаа Боловсрол, шинжлэх ухааны яам, Отгонтэнгэр их сургууль, СЭЗИС-тай хамтран хэрэгжүүллээ. ERASMUS+MONGWBL төслийн хүрээнд нийт 85 оюутан Голомт банканд “Ажлын байранд суурилсан сургалтын хөтөлбөр”-т хамрагджээ.
- Голомт банкны нэрэмжит “Оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийг 19 дэх жилдээ амжилттай зохион байгуулж, шилдэг 100 оюутныг шалгаруулан сургалтын тэтгэлэг гардууллаа.
- “Голомтын төгөл”-д 4 дэх жилдээ 200 гаруй гацуур мод тарьж, суулгалаа.

Арга хэмжээ

Managers' meeting

Голомт банкны стратеги, зорилго, зорилтыг амжилттай хэрэгжүүлэх, удирдах ажилтны манлайллыг хөгжүүлэх зорилгоор “Managers' Meeting-2023” арга хэмжээг хэрэгжүүллээ.

New talent

Голомт банк шинэ ажилтнуудаа байгууллагын соёлд нэгтгэх, бэлтгэн чиглүүлэх, дасан зохицоход нь дэмжлэг үзүүлэх цогц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилладаг. Тухайлбал, шинэ ажилтныг байгууллагын соёлтой танилцуулах зорилготой “New talent” outdoor training хөтөлбөрийг тав дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Гадаад аялал

Голомт банк жил бүр ажилтнуудынхаа гаргасан амжилт, ур чадварыг нь үнэлж, дүгнэн шилдэг ажилтнуудаа мөнгөн шагнал, гадаадад аялах эрхээр шагнадаг уламжлалтай. 2023 онд ажил үйлсээрээ манлайлсан шилдэг 32 ажилтан АНЭУ-ын Дубай хотод аялав.

Хөрөнгийн удирдлага

Монгол Улсад
анх удаа Хувь
хүний хөрөнгийн
удирдлагын
үйлчилгээг банкны
Хөрөнгө оруулалтын
хадгаламжийн
бүтээгдэхүүнээр
дамжуулан
дотоодын
харилцагчдадаа
хүргэж эхэллээ.

Голомт Банк 2023 онд Актив, пассивын удирдлагын хүрээнд Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж, эрсдэлийг зохистой түвшинд удирдаж ажилласан ба активын ашиглалтыг сайжруулан, зардлаа бууруулах замаар ашигт ажиллагааг сайжруулаад байна.

Зохистой харьцаа

Актив, пассивын эргэн төлөлтийн хугацааны зөрүүг харилцагчдын зан төлөв дээр суурилан тооцох аргачлалыг сайжруулж, хүүгийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ тогтмол удирдаж ажиллалаа.

Банк хөрвөх чадвараа өндөр түвшинд хадгалж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг тогтмол 30 хувиас дээш хангаж ажиллахын хажуугаар Базелын хорооны хөрвөх чадварын харьцааны үзүүлэлтүүд болох LCR (30 хоногийн хөрвөх чадвар), NSFR (1 жилийн тогтвортой эх үүсвэр)-ийн үзүүлэлтүүдийг тооцож, тогтмол 100 хувиас дээш хангаж ажиллаад байна.

Мөн банк өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааг зохистой түвшинд барьж, өөрийн хөрөнгийн хүрэлцээгээ хангаж ажиллалаа.

Ашигт ажиллагаа

2023 онд сул активын ашиглалтыг сайжруулахад анхаарч, бондын зах зээлд оролцон Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж ажиллахаас гадна COVID 19 цар тахлын дараах эдийн засгийн хүндрэлтэй үед ноолуур бэлтгэлийн зээл, хүнс болон хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээл зэрэг эдийн засгийг дэмжих зорилготой хөтөлбөрүүд дээр оролцож жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээл олголоо.

Цаашлаад, банк нь зах зээлийн хүүгийн хөдөлгөөн болон өрсөлдөөнд хурдан хариу үзүүлж, цаг алдалгүй харилцах, хадгаламж болон зээлийн хүүгийн нөхцөлийг өөрчлөн, цэвэр хүүгийн ахиуцаа нэмэгдүүлээд байна.

Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээ

Голомт банк 2023 онд Монгол Улсад анх удаа Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээг (Private Wealth Management) банкны Хөрөнгө оруулалтын хадгаламжийн бүтээгдэхүүнээр дамжуулан дотоодын харилцагчдадаа хүргэж эхэллээ.

Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээ (Private Wealth Management Service) бол харилцагчийн хөрөнгө оруулалтын зорилго, эрсдэл даах чадварын хүрээн дэх хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ юм. Голомт банк Хувь хүний хөрөнгийн удирдлагын үйлчилгээний хүрээнд харилцагчдад багцын хөрөнгө оруулалт болон дагалдах консьерж үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Энэхүү үйлчилгээний гол зорилго нь өндөр дүнтэй хадгаламж эзэмшигч, хөрөнгө оруулагч, хөрөнгө эзэмшигчид рүү чиглэж, тэдгээрийн хөрөнгийг оновчтой багц бүрдүүлэх замаар удирдахад оршдог. Цаашид үйлчилгээний цар хүрээг тэлэн, хүртээмжтэй байдлаар харилцагчдадаа хүргэх зорилт тавин ажиллаж байна.

2023 онд Голомт банк нээлттэй гадаад валютын позицуудын хувьд Монголбанкнаас тогтоодог шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажиллалаа.

Эрсдэлийн удирдлага

Голомт банк эрсдэлийн засаглал, “Гурван шугамын загвар”, эрсдэл даах чадвар, стресс тестийн үр дүнд суурилсан эрсдэл даах чадварын нөөц интервал бүрдүүлэлт, эрсдэлийн аппетитийн мэдэгдэл, гэрлэн дохионы аргачлал зэрэг Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хамаарах үндсэн бүрэлдэхүүнүүдийг улам төгөлдөржүүлж, дотооддоо мөрдөн ажиллаж байна.

Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос гаргасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний дотоод үнэлгээний аргачлал (ICAAP)-ыг банк дотооддоо тооцож, нэгтгэсэн стресс тестэд ашиглах замаар холбогдох хороонд танилцуулан өөрийн хөрөнгийн хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Эрсдэлийн удирдлагын тогтолцоонд “Гурван шугамын загвар”-ыг дараах байдлаар тодорхойлон банкны бүх нэгжүүдийн чиг үүрэг, төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээг уялдуулан ажиллаж байна. Үүнд:

- Банкны бодлого, журам болон өөрсдийн чиг үүргийн хүрээнд өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа эрсдэлийг хариуцан ажилладаг бизнес нэгжүүд болон тэдгээрийг дэмжих чиг үүрэгтэй нэгжүүд “Нэгдүгээр шугам”-д хамаарна.
- “Нэгдүгээр шугам”-д хамаарах нэгжүүдийн эрсдэлээ хэрхэн удирдаж байгаад хяналт тавих, банкны хэмжээнд ямар хэмжээний эрсдэл хүлээж байгааг хянах, хязгаарлах чиг үүрэгтэй нэгжүүд “Хоёрдугаар шугам”-д хамаарна.
- Хараат бус дотоод аудитын чиг үүрэгтэй нэгжүүд “Гуравдугаар шугам”-д хамаарна.

Зээлийн эрсдэлийн удирдлага

Голомт банкны зээлийн эрсдэлийн удирдлага нь зээлдэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас банкны алдагдал хүлээх эрсдэлийг удирдан ажиллаж, банкны ашигт ажиллагаа, өгөөжийг хамгийн өндөр түвшинд хүргэхээр төлөвлөн ажилладаг.

Голомт банк зээлийн багцын оновчтой удирдлагыг хэрэгжүүлсний үр дүнд зээлийн багцын тоон зорилт болох зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээний харьцаа 106.2 хувьтай, чанаргүй зээлийн харьцаа 177.4 хувийн гүйцэтгэлтэйгээр биелж, чанарын зорилт бүрэн хангагдсан.

Голомт банк
зээлийн багцын
оновчтой
удирдлагыг
хэрэгжүүлсний
үр дүнд зээлийн
багцын тоон зорилт
болох зээлийн
эрсдэлийн сангийн
хүрэлцээний
харьцаа 106.2
хувьтай, чанаргүй
зээлийн харьцаа
177.4 хувийн
гүйцэтгэлтэйгээр
биелж, чанарын
зорилт бүрэн
хангагдлаа.

“СТОУС-9”-д нийцүүлсэн санхүүгийн тайланг автоматжуулах

Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Зөвлөл (ОУНББЗ)-өөс батлан гаргасан “Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт 9” (IFRS-9) стандарт Банк 2018 оноос олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй зэрэгцэн Голомт банк амжилттай нэвтрүүлж, жил бүр Олон Улсын хөндлөнгийн аудитаар баталгаажуулж байна. 2023 оноос Голомт банк энэхүү стандартаар санхүүгийн тайлагналыг бүрэн автоматжуулах төслийг эхлүүлсэн. Ингэснээр банк сар бүрийн давтамжтайгаар СТОУС-9 стандартаар тайлагнах боломжтой болох юм.

Банкны зээлийн үйл ажиллагааг сайжруулах

Банкны зээлийн шийдвэр гаргалтыг хурдасгах зорилгоор 2023 оноос “Business process management suites” систем буюу зээлийн үйл ажиллагааны бүтэн процессыг автоматжуулах, нэгдсэн өгөгдлийн сантай болох төслийг амжилттай хэрэгжүүлж байна.

Зээлийн үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг сайжруулах

Зээлийн үйл ажиллагааны өр цуглуулах процессыг төвлөрүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор “Зээл цуглуулах газар”-ыг шинээр байгууллаа. Ингэснээр банкны хугацаа хэтэрсэн зээл, чанаргүй зээл болон тусгай актив барагдуулах үйл ажиллагаа нь нэгдсэн бодлого, зохицуулалт болон өдөр тутмын удирдлага, зохион байгуулалтаар хангагдаж, зээлийн багцын чанар болон ашигт ажиллагаа илүү сайжрах юм.

Банкны өдөр тутмын зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй Зээлийн газар нь өмнө Том болон Дунд байгууллагын зээлийн эрсдэлийг илүү удирдахад чиглэсэн бүтэцтэй байсан бол 2023 оноос Иргэдийн зээл болон Жижиг зээлийг хариуцсан хэлтсүүдтэй болж, зээлийн судалгааны процесс нэг нэгжид бүрэн төвлөрч байна. Түүнчлэн тус нэгжийн харьяанд “Мэргэшүүлэх алба”-ыг шинээр байгуулснаар зээлийн судалгааны ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг сайжруулах нөхцөл бүрдлээ.

Зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо

Голомт банкны Зээлийн эрсдэлийн удирдлагын хэлтэс нь зээлийн багцын стресс тестийн аргачлалыг хөгжүүлж, хүндрэлтэй нөхцөл байдалд хэрэгжүүлэх хариу арга хэмжээг төлөвлөн зээлийн багцын удирдлагыг хэрэгжүүлж байна. Түүнчлэн Голомт банк сүүлийн 6 жилийн хугацаанд барилга, уул уурхай, аж үйлдвэрлэл зэрэг эдийн засгийн мөчлөгт өртөмтгий салбаруудаас хамаарах хамаарлыг багасгах бодлого баримтлан ажиллаж ирсэн. Үүний үр дүнд зээлийн багцаас хүлээх төвлөрлийн эрсдэлийг сегмент болон эдийн засгийн секторын хувьд оновчтой тархаасан. Цаашид Голомт банк зээлийн багцын төвлөрлийг үргэлжлүүлэн бууруулж, зээлийн багцын чанарыг хадгалсан багцын тогтвортой өсөлтийг бий болгохоор зорьж байна.

Барьцаа хөрөнгийн бодлого

Банк барьцаа хөрөнгийн бодлогын дагуу зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив болон хүлээж болзошгүй үүрэгт зээлдэгч болон гуравдагч этгээдээс үүргийн гүйцэтгэлийг хангуулах баталгаа болгож барьцаа шаарддаг.

Үл хөдлөх хөрөнгийн барьцааны төрөл, онцлогоос хамааран орон сууц, оффис, худалдаа, дулаан зогсоол, амины орон сууц зэрэг үл хөдлөхийн төрөл тус бүрд барьцаа хөрөнгийн жишиг үнийг мөрдөж, хагас жил тутамд шинэчилдэг бөгөөд барьцаа хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа нь Үнэлгээний Олон Улсын Стандарт (IVS)-ын дагуу нийцтэй байдаг.

2024 онд барьцаа хөрөнгийг үнэлэх хурдыг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг автоматжуулах, мэдээллийн баазыг баяжуулж, дата удирдлагын стандартыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт нь санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэн болон ирээдүйн мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж алдагдал хүлээх эрсдэл юм. Хүү, валютын ханш, арилжаа, хөрөнгө оруулалтын зориулалттай үнэт цаас, хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт эсвэл зах зээлийн хөдөлгөөнөөс хамаарч банкны нээлттэй байгаа позицод зах зээлийн эрсдэл нэмэгддэг.

Тайлант хугацаанд санхүүгийн зах зээлд валютын ханш, хувьцаа, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, зэрэг эрсдэлүүд тулгарсан ч банк зах зээлийн эрсдэлийн удирдлагын оновчтой бодлого хэрэгжүүлснээр болзошгүй алдагдлаас хамгаалж, эрсдэлийн удирдлагын тогтолцоог улам бэхжүүлэн ажиллаж байна.

2023 онд Голомт банк нээлттэй гадаад валютын позицуудын хувьд Монголбанкнаас тогтоодог шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажиллалаа. Түүнчлэн АПХ-оос батлагдсан лимитийн хүрээнд валютын ханшийн эрсдэлээс учирч болзошгүй алдагдлыг "Value at Risk" аргачлалаар тооцож, өдөр бүр хяналт тавин ажиллаа.

Мөн харилцагч тал болон улс орны эрсдэлийг харилцагч харилцагчийн зээлжих зэрэглэл болоод санхүүгийн харьцаа үзүүлэлтэд үндэслэн харилцагч нэг бүрийн хувьд лимитийг тодорхойлж, гүйцэтгэлд өдөр бүр хяналт тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд банк өөрийн хөрөнгийн хүрэлцээний хувьд Монголбанкнаас тогтоодог шаардлагуудыг хангахаас гадна банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд бүрэн нийцүүлэн ажиллалаа. Мөн Базел III стандартын дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ICAAP)-ыг ашиглан учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, стресс тестийг тогтмол гүйцэтгэж өөрийн хөрөнгийн эрсдэлийг удирдан ажиллаж байна.

Голомт банк хүүгийн зохистой түвшнийг бодлогын хүү, зах зээлийн өрсөлдөөн зэрэг олон талт нөхцөл байдлаас хамааруулан тодорхойлдог. Уг хувьсан өөрчлөгдөж буй зах зээлийн орчинд банк нь богино хугацаанд цэвэр хүүгийн орлогод үүсэх өөрчлөлт (NII)-ийг, урт хугацаанд өөрийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнэд үзүүлэх нөлөөлөл (ΔEVE)-ийг үнэлж, хүүгийн өөрчлөлтийн стресс нөхцөлд учирч болзошгүй аливаа эрсдэлүүдийг тодорхойлж удирдан ажилладаг.

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь бэлэн мөнгө эсвэл бусад хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөөр санхүүгийн өр төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэл үүсэх эрсдэл юм. Банкны хөрвөх чадвар 2023 оны турш Монголбанкнаас тогтоосон зохистой түвшин болон банкны өөрийн эрсдэлийн аппетитийн мэдэгдлийн хүрээнд хангалттай өндөр түвшинд байлаа. Банкны хяналт шалгалтын Базелийн хорооноос тогтоосон стандартын дагуу банк богино хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор хөрвөх чадварын хүрэлцээтэй байдлын харьцаа (LCR), дунд урт хугацааны хөрвөх чадварын эрсдэлийг удирдах, хяналт тавих зорилгоор цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцааг (NSFR) тогтмол тооцож, хангаж ажиллалаа.

Банкны хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг улам сайжруулах, учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор банкны дотоод бодлого, журам, аргачлал, хүндрэлийн үеийн төлөвлөгөөг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлж, мөрдөн ажиллалаа. Түүнчлэн Базел III стандартын дагуу хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх аргачлал (ILAAP)-аар учирч болзошгүй хөрвөх чадварын эрсдэлийг тодорхойлж, стресс тестийг тогтмол гүйцэтгэн, үр дүнг шийдвэр гаргалтад ашиглан хөрвөх чадварын эрсдэлийг удирдан ажиллаж байна.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь банкны дотоод үйл ажиллагаа, системүүдийн хяналтын хангалтгүй байдал, гадаад орчны таагүй нөлөөлөл болон хүний хүчин зүйлээс шалтгаалан эрсдэлийн зохистой түвшнийг хангаж чадахгүй болохыг хэлнэ.

Банкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтыг оновчтой болгох ажлыг системийн тусламжтайгаар гүйцэтгэж ажилласны үр дүнд үйл ажиллагааны эрсдэлийн аппетитийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.

Эрсдэлийн соёлын хөтөлбөр

Банк нь жил бүр Эрсдэлийн соёлын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хөтөлбөрийн хүрээнд ёс зүй, эрсдэлийн удирдлага, мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, мэдээллийг бататгах, дээшлүүлэх сургалт, өдөрлөгийг зохион байгуулдаг. 2023 онд банкны нийт салбар, нэгжүүдийн Ёс зүйн төлөөлөгч нарыг хамруулан “Ёс зүй, Эрсдэлийн форум”-ыг амжилттай зохион байгууллаа.



Банкны ёс зүйн төлөөлөгч нар
2023 оны 10-р сар

Бизнесийн тасралтгүй ажиллагаа

Үйл ажиллагааны хэвийн тасралтгүй байдлыг хангаж, улмаар сайжруулах зорилгын хүрээнд гадны байгууллагаас “ISO 22301 Бизнесийн тасралтгүй ажиллагааны менежментийн тогтолцоо”-г нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ авч, шат дараатай үйл ажиллагаандаа нэвтрүүлж байна. Уг зорилгын хүрээнд Бизнесийн тасралтгүй ажиллагааны бодлого болон Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөөг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн боловсруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл

Голомт банк олон улсын нэр хүнд бүхий мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болох ISO27001:2013 стандарт, Төлбөрийн картын аюулгүй байдлын PCI-DSS 3.2.1 стандартууд болон хувь хүний өгөгдөл хамгааллын хуулийн хэрэгжилтийг хангах GDPR буюу Европын холбооны хувь хүний өгөгдөл хамгаалах тухай хуулийн шаардлага тус бүрийг ханган үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.



2017 оны
7-р сараас хойш



2018 оны
3-р сараас хойш



2018 оны
10-р сараас хойш

Мөн системийн аюулгүй байдлыг бүрэн хангаж буй эсэхийг хөндлөнгийн мэдээллийн аюулгүй байдлын аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаар банкны системийн эмзэг байдлын үнэлгээг тогтмол хийж баталгаажуулдаг. Банкны систем руу чиглэсэн гадны кибер халдлагаас хамгаалах зорилгоор Security Operations Maturity Model (SOMM) стандартын шаардлагуудыг бүрэн хангасан Кибер Аюулгүй Байдлын Удирдлагын төвийг (КАБУТ)-г бий болгон ажиллаж байна. Энэхүү төв нь 24/7 бодит цагийн горимоор хяналтыг хэрэгжүүлэн илэрсэн халдлага, довтолгоог зогсоох, хариу арга хэмжээ авах (SOAR), урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Банкны кибер аюулгүй байдлын хамгаалалтын тоног төхөөрөмж, программ хангамжууд нь олон улсын судалгааны байгууллагуудаар үнэлэгдэж, салбартаа шилдэг (Leader) шийдлүүдийг ашиглаж байна.

Голомт банк хүнээс шалтгаалсан мэдээлэл алдагдах эрсдэлийг бууруулах, удирдах зорилтын хүрээнд нийт ажилтнууддаа Мэдээллийн аюулгүй байдлын сургалт, халдлагын симуляциуд, зөвлөмжүүдийг тогтмол хүргүүлдэг. Банкны системүүд рүү ажилтнуудын хандах үйл ажиллагааг олон улсын шилдэг туршлагууд (Zero Trust) дээр тулгуурлан хяналт тавьж ажиллаж байна. Мэдээллийн аюулгүй байдлын нэгж нь банкны ажилтнуудын үндсэн системүүдийн эрхийн хяналтыг тогтмол хийж гүйцэтгэдэг нь дотоод залилан, луйвар гаргахаас урьдчилан сэргийлж байна.

Банкны интернэт хандалттай болон дотоод системүүдийн эмзэг байдлын шалгалтыг олон улсын хөндлөнгийн болон дотоодын шилдэг гэрээт кибер аюулгүй байдлын экспертүүд хийж гүйцэтгэдэг. Мөн “Open Bug Bounty” хөтөлбөр буюу олон улсын ёс зүйт хакерууд нь банкны системээс эмзэг байдлыг илрүүлэн урамшуулал авах хөтөлбөрт Голомт банк нэгдсэн. Ингэснээр эмзэг байдал ашиглан харилцагчийн мэдээлэл рүү халдах гэсэн оролдлогыг цаг алдалгүй мэдэх боломжтой болсон.

Түүнчлэн дэлхийн өнцөг бүрийн 1100 гаруй байгууллага нэгдсэн кибер аюулгүй байдлын олон улсын хамтын ажиллагааны хамгийн төсөл болох Парисын Кибер орчин дахь аюулгүй байдлыг хангах харилцан итгэлцлийн уриалгад нэгдэн туршлага солилцож байна.

Голомт банк Монголын Банкны Холбоо, Цагдаагийн Ерөнхий Газар, Монголбанктай хамтран цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Ятгах тусам нягтал” аяныг “Залилагчид боломж бүү олго” уриатайгаар 2020, 2021 онд, “Бүү шилжүүлээрэй” уриатай “UNSEND” аяныг 2022 онд, Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой “Цахим зөвлөмж” аяныг 2023 онд хамтран зохион байгуулсан. Уг аяны хүрээнд цахим залилангаас сэргийлэх мэдээ, мэдээллүүдийг нийгмийн сүлжээ, телевиз радио болон хэвлэл мэдээллийн сувгуудаар явуулсан.

Голомт банкны Мэдээллийн аюулгүй байдлын баг нь 2023 онд Саудын Араб улсад зохион байгуулагдсан BlackHat MEA 2023 CTF ёс зүйт хакерийн тэмцээний финалын шатанд амжилттай оролцлоо. Тэмцээний сонгон шалгаруулалтад олон улсын 750 баг оролцсоноос шалгарсан дэлхийн шилдэг 250 баг Саудын Араб улсад зохион байгуулагдсан финалын шатны тэмцээнд өрсөлдөж, Голомт банкны баг 21-р байр эзэллээ.



Комплаенс

Комплаенсийн хэлтэс нь Голомт банкны Ерөнхийлөгчийн шууд удирдлага дор ажиллаж, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын багт тодорхой давтамжтай ажлаа тайлагнадаг. Ерөнхий комплаенсийн холбогдох асуудлууд болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үндсэн чиг үүргийг хариуцдаг мэргэжлийн нэгж юм.

Голомт банк Монгол Улсын МУТСТ тухай хууль болон олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага болох Financial Action Task Force ("FATF")-ийн МУТСТ стандартын хэрэгжилтийг үр дүнтэй хангахаар анх 2007 онд Мөнгө угаахтай тэмцэх нэгжийг үүсгэн байгуулж, өдгөө 17 жилийн турш уг үйл ажиллагааг улам боловсронгуй болгон ахисан түвшинд хэрэгжүүлж байна. Банк нь МУТСТ хуульд заасны дагуу харилцагчаа таньж мэдэх, гүйлгээний хяналтыг хэрэгжүүлэх, олон улсын хориг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой хүний нөөц, программ хангамж, сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийдэг. Комплаенсийн хэлтэс нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиг үүргийн хүрээнд олон улсын стандарт, тэргүүн туршлагыг судлах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг. Энэ ажлын хүрээнд Комплаенсийн нэгжийн ажилтнуудыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, боловсролтой мэргэшсэн хүний нөөц болгоход анхааран ажиллаж байна.

Голомт банк 2023 онд дотоод хяналтын тогтолцоогоо сайжруулахаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд:

- Олон улсын геополитийкийн нөхцөл байдалтай холбоотой банкны гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаанд Комплаенсийн хяналтыг улам чангатгаж, олон улсын хориг арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулав.
- Банкны ёс зүйн соёлыг дэлгэрүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аливаа ёс зүйн зөрчлийг үл тэвчих, холбогдох арга хэмжээг авах үйл ажиллагааны хүрээнд Ёс зүйн зөрчлийг мэдээлэх /Шүгэл үлээх зааврыг шинэчлэн батлуулж, дижитал хэлбэрт оруулан ажилтнуудад нээлттэй байршуулав.
- Нэгжийн ажилтнуудыг мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх ажлын хүрээнд гадаад, дотоодын мэргэжлийн байгууллагуудын сургалт, семинарт хамруулав.
- Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд өндөр эрсдэл бүхий үйл ажиллагаа, бизнес, салбар, нэгж, харилцагчийн төрөл болон бүтээгдэхүүн, үйлчилгээнд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажиллав.

Банкны хэрэгжүүлж буй Комплаенсийн дотоод хяналтын хөтөлбөрт ажилтнуудын мэдлэг маш чухал байр эзэлдэг. Тиймээс бид банкны бүх түвшний ажилтанд комплаенс, тэр дундаа мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл болон тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар цогц хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулдаг.

2023 онд банкны хэмжээнд давхардсан тоогоор нийт 2537 (танхим болон цахим хэлбэрээр) ажилтан холбогдох сургалтуудад хамрагдсан байна. Ажилтнуудын сургалтаас олж авсан мэдлэгийг бататгах зорилгоор жилд нэг удаа комплаенсийн сэдвээр онлайн шалгалтыг тест хэлбэрээр авдаг ба 2023 онд банкны нийт ажилтнуудын 90 гаруй хувь нь уг шалгалтыг амжилттай өгч тэнцсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан Комплаенсийн бодлогын дагуу 2017 оноос хойш банкны Засаглалын кодекс дахь зарчим, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах, хянах, “Tone at the Top” болон ёс зүйт ажилтны соёлыг дэлгэрүүлэх, ёс зүйн зөрчлийг арилгах зорилго бүхий Ёс зүйн төлөөлөгчдийг бүх салбар, нэгжээс томилж банкны хэмжээнд нийт 146 төлөөлөгчийг ажиллуулж байна. 2023 онд Голомт банк 2 жил тутам зохион байгуулагддаг “Ёс зүйн төлөөлөгчдийн форум”-ыг 3 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа.



Санхүүгийн Тайлагналын
Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн
Санхүүгийн тайлангууд болон
Хараат бус аудиторын тайлан
2023 оны 12 дугаар сарын 31



Байгууллагын талаарх мэдээлэл

Үүсгэн байгуулах шийдвэр

Голомт Банк (цаашид “Банк” гэх) нь 1995 оны 3 дугаар сарын 6-ны өдөр анх үүсгэн байгуулагдсан.

Гэрчилгээ ба Лиценз

Банк нь 2023 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр Монгол Улсын Улсын бүртгэлийн ерөнхий газраас шинээр олгосон 2075377 тоот регистрийн дугаар бүхий 9007001012 тоот Улсын Бүртгэлийн гэрчилгээг эзэмшдэг.

Банк нь 1995 оны 3 дугаар сарын 6-ны өдөр банкны үйл ажиллагаа эрхлэх 25 тоот Тусгай зөвшөөрлийг Монголбанкнаас авсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ч.Мөнхцэцэг	ТУЗ-ийн дарга
Урс Е.Шварценбах	ТУЗ-ийн гишүүн
Д.Мөнхтөр	ТУЗ-ийн гишүүн
Л.Болормаа	ТУЗ-ийн гишүүн
О.Ганжолоо	ТУЗ-ийн гишүүн
Ж.Үнэнбат	ТУЗ-ийн гишүүн
Лопез Абелло	Хараат бус гишүүн
Жэймс Б.Двайер	Хараат бус гишүүн
Александр Пикер	Хараат бус гишүүн
Роберт В.Ван Свитен	Хараат бус гишүүн

Гүйцэтгэх Удирдлага

К.Норихико	Гүйцэтгэх захирал
Г.Ганболд	Ерөнхийлөгч
А.Одонбаатар	Гүйцэтгэх захирлын орлогч
М.Сайнбилэг	Мэдээллийн технологи хариуцсан захирал
С.Мөнхтуяа	Санхүүгийн удирдлагын газрын захирал
М.Наранхүү	Зээлийн газрын захирал
Т.Отгон	Эрсдэлийн удирдлагын газрын захирал
Б.Содболор	Нөөцийн удирдлагын газрын захирал
Ц.Байгалмаа	Иргэдийн банкны газрын захирал
Н.Очирхуяг	Маркетинг, олон нийттэй харилцах газрын захирал
Г.Уянга	Хүний нөөцийн удирдлагын газрын захирал
Б.Сугар-Эрдэнэ	Байгууллагын банкны газрын захирал
А.Ганчимэг	Байгууллага хөгжлийн газрын захирал
Ё.Пүрэвбат	Бүртгэл тооцооны газрын захирал
Б.Энхзаяа	Олон улсын банкны газрын захирал
Х.Пүрэвдорж	Захиргааны газрын захирал
О.Батцэнгэл	Мэдээллийн технологийн газрын захирал
А.Нямсүрэн	Бизнес процесс менежментийн газрын захирал

Гүйцэтгэх Удирдлага

Голомт Банкны төв байр
Сүхбаатарын талбай 5, Ш/Х-22
Улаанбаатар 15160, Монгол Улс

Аудитор

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Блю Скай Тауэр, 6 давхар, 602 тоот
Энхтайваны өргөн чөлөө 17, Сүхбаатар дүүрэг 1-р хороо
Улаанбаатар хот 14240, Монгол Улс

Удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Голомт Банк ХК (цаашид "Банк" гэх)-ийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Банкны санхүүгийн тайлан нь СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн. Банкны удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2-оос 6-д дурдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн Банкны удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан ашиглан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогыг сонгож, тууштайгаар хэрэглэж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлэмж хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг шийдвэрийн дагуу зөвшөөрч батлав.



Ч.МӨНХЦЭЦЭГ

ГОЛОМТ БАНК
Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн дарга

К.НОРИХИКО

Гүйцэтгэх захирал

С.МӨНХТУЯА

Санхүүгийн Удирдлагын
Газрын захирал

Улаанбаатар,
Монгол Улс

Огноо: 2024 оны 3 дугаар сарын 27



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бүс Аудиторын Тайлан

Голомт Банк Хувьцаат Компанийн Хувьцаа Эзэмшигчид болон Төлөөлөн Удирдах Зөвлөлд:

Дүгнэлт

Бид Голомт Банк ХК (цаашид “Банк” гэх)-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн орлого, үр дүнгийн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү санхүүгийн тайлан нь Банкны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (цаашид “СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бүс Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Банкнаас хараат бүс байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Онцлох Асуудал

